

УЛС ТӨР

⊖ УИХ гүйцэтгэх засаглалыг хянах чадамжаа алджээ → 2

ЗГМ: СЭДЭВ

⊖ Багш нарыг хангалттай бэлтгэхгүй бол 10 жилийн дараа өнөөдрийн ачаалал буурахгүй → 4


НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

⊖ Баян, ядуугийн ялгаа нэмэгдэх хэрээр дундаж давхарга хумигдсаар → 7

ZGM DAILY

⊖ FULL ENGLISH PAGE INSIDE → 20-21

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ



2020.01.22, ЛХАГВА~№014 (1293)

~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ	ЗЭС	ТӨМРИЙН ХҮДЭР	НЕФТЬ	ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	САМУРАЙ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ	ВОН
1,555.30 0.32%	6,259.00 0.22%	640.00 1.54%	62.86 0.65%	104.92	114.74	102.38	103.19	2748.32	398.08	44.45	2.36

Дөрвөн хүний амь бол ердөө эхлэл

Өөртөө хайртай бол Цагаан сарын shopping аялалд явахаасаа өмнө дахин нэг бод



⊖ БНХАУ-д дэгдсэн SARS цагаан сарын аялагчдын хөлөөр дамжин геометр проектоор тархаж нь тодорхой болоод байна. Харин Монголд эрсдэлийн үнэлгээ л хийж сууна.

cnn.com

→ 6

⊖ С.Шаарийбуу Ерөнхийлөгчтэй дахин уулзах хүсэлтээ илэрхийллээ → 3

Тэрбээр сэтгэл санаа, эрүүл мэндэд учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр Малайзын Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, нотлох баримтуудаа шинээр бүрдүүлэх шаардлагатай болоод байгаа юм

⊖ Дэлхийн эдийн засгийн чуулган нэгдмэл оролцоог чухалчилж байна → 8

⊖ Н.Алимаа: Брэндээ олон улсын зах зээлд гаргахаар ажиллаж байна



→ 17

Өнөөдөр	Маргааш
-13°C ☁	-14°C ☁
-20°C 🌙	-25°C 🌙



Bloomberg TV Mongolia AWARDS 2019



19:00 цагт
2020 оны 1 сарын 31
Shangri-La Hotel Ballroom

Bloomberg TV Mongolia

Шинэ Эдийн Засгийн Форум

09:00 цагт
2020 оны 1 сарын 31
Shangri-La Hotel, Ballroom

Спонсор байгууллагууд:



Спонсор байгууллагууд:



УЛС ТӨР

ЗГМ: ТОВЧХОН

■ ПАРЛАМЕНТ

Халдашгүй байдлын дэд хорооны гишүүд Н.Номтойбаяр гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдэхээр цугласан боловч дахин хойшууллаа. Харин тус хорооны хурлыг нээлттэй явуулах Н.Номтойбаяр гишүүний хүсэлтийг хүлээн авахгүй гэсэн байна.

■ ЯАМ

Тэтгэврийн зээл тэглэх зорилгоор Сангийн яамнаас Монголбанк, “Эрдэнэс Монгол” компанийн төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулжээ. Тус ажлын хэсэг сар шинийн баяраас өмнө тэтгэврийн зээлийг тэглэхээр төлөвлөж буйг “Эрдэнэс Монгол” компанийн захирал П.Ганхүү мэдээлэв.

■ ШИЙДВЭР

УИХ-ын Ёс зүйн дэд хороо хуралдаж “Бид уучлахгүй” хөдөлгөөнөөс гаргасан УИХ-ын гишүүн Л.Болд, Оюунчимэг нарыг үндэслэлгүй хөрөнгөжсөн гэх гомдлыг хэлэлцэн дээрх гишүүдийг үйл ажиллагаа нь эхлээгүй компани ХОМ-тээ бүртгүүлээгүйгээс техникийн алдаа гарсан гэж үзжээ.

БАЙНГЫН ХОРОО

Гэр бүлийн тухай хуульд хоёр бүлэг, 26 зүйл шинээр нэмнэ

УИХ-ын Хууль зүйн байнгын хороо Гэр бүлийн тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцэхийг дэмжлээ.

Гэр бүл цуцлалт сүүлийн таван жилд 3.6 хувиар өсөж, өрхийн санхүүгийн хүртээмжгүй байдал, хосын тааламжгүй харилцаа, хүчирхийлэл, гэр бүл цуцлалтын үр дагавар хүүхдэд хүндээр тусаж, эрх нь зөрчигддөг зэрэг олон асуудлыг шийдвэрлэхийн тулд тус хуулийг шинэчлэн батлахаар зорьж буй юм.

Гэр бүлийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэрлэлт сайн дурын байх, гэрлэгсэд тэгш эрхтэй байх, гэр бүлийн асуудлыг гэр бүлийн гишүүд харилцан тохиролцож, шийдвэрлэх, хариуцлагатай байх, хүүхдийг гэр бүлд нь өсгөн хүмүүжүүлэх, хүүхдийн ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах зарчмыг баримталжээ. Мөн тус хуулийн 80 гаруй хувьд өөрчлөлт оруулах бөгөөд хоёр бүлэг, 26 зүйл шинээр нэмэх юм. ■

УИХ гүйцэтгэх засаглалыг хянах чадамжаа алджээ



Гэрэл зургийг С.Батсайхан

Парламент 2019 онд Ерөнхий сайдын мэдээллийг ганцхан удаа сонссон байна

Б.Гарьд, ЗГМ сонин

УИХ-ын үндсэн үүргийн нэг нь гүйцэтгэх засаглалыг хянах үүднээс Ерөнхий сайдын мэдээллийг сонсдог. Ийн парламентын баталсан хууль, бодлого хэрхэн хэрэгжиж буйд дүгнэлт хийж, улмаар сайжруулах үүрэг чиглэл өгдөг. Гэтэл өнгөрсөн онд УИХ-ыг эл үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэж болохоор байна.

УИХ-ын даргын зөвлөлөөр тухайн долоо хоногт хэлэлцэх Ерөнхий сайдын мэдээллийг сонсох төлөвлөгөө гаргадаг ч өнгөрсөн онд энэ ажилд огт анхаарал хандуулсангүй. Тухайлбал, өнгөрсөн нэг жилийн хугацаанд УИХ-ын чуулганаар Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн мэдээллийг сонсохоор 11 удаа

төлөвлөж баталсан ч ердөө ганцхан удаа мэдээллийг нь сонсжээ. Тухайлбал, 2019 оны тавдугаар сард Ерөнхий сайд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын явцын талаар чуулганы хуралдаанд мэдээлэл хийснээс өөр мэдээ алга. Уг нь үүнээс гадна Засгийн газраас Эдийн засгийн коридор байгуулах, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, ач холбогдол, бэлтгэл ажлын явц, төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилт зэргийг 10 удаа чуулганд

танилцуулахаар парламентад мэдээллээ хүргүүлсэн ч таг чиг. УИХ-ын даргын зөвлөлөөр боловсролын бодлогын хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийг сонсохоор таван удаа төлөвлөсөн ч өнөөг хүртэл ажил хэрэг болгоогүй байна. Хамгийн сүүлд гэхэд л өнгөрсөн баасан гарагийн хуралдааны төгсгөлд энэ сэдвээр гишүүд мэдээлэл сонсохоор төлөвлөөд бас л бүтсэнгүй.

Мөн парламентын гишүүд гүйцэтгэх засаглалын ажлыг хянах, тойрогт нь хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн явцын талаар мэдээлэл авах, үүрэг чиглэл өгөх зорилгоор Ерөнхий сайд болон салбарын сайд нарт хандан асуулга тавьж, чуулганаар хэлэлцдэг уламжлалтай. Өнгөрсөн жилийн хувьд мөн л энэ ажил урагшгүй байв. Ялангуяа, УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнийн

бэлчээрийн талхалдал, цөлжилт, ой, хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын талаар Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг УИХ-ын нэгдсэн чуулганд сонсох гэж дөрвөн удаа төлөвлөсөн юм. Б.Бат-Эрдэнэ гишүүн УИХ-ын чуулганы эхэнд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх гомдоллосны эцэст өнгөрсөн оны 11 дүгээр сард түүний хүсэлтийг барагдуулжээ.

УИХ-ын чуулганаар гишүүдийн тавьсан асуулгын хариуг сонсох

ажил өнгөрсөн жилүүдийнхээс муу байгааг тоон үзүүлэлт ч

харуулж байна. Тухайлбал, 2018 онд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд 12 удаа гишүүдийн тавьсан асуулгад хариулт өгөхөөр чуулганы хуралдаанаар “байцаагдсан” бол 2019 онд энэ тоо бүр гурав дахин буурчээ. Өнөөдрийн байдлаар Х.Болорчулуун, Д.Оюунхорол, С.Бямбацогт, Б.Баттөмөр, Д.Хаянхярваа, Б.Жавхлан, Н.Амарзаяа, Н.Оюундарь зэрэг 20 шахам гишүүн асуулгынхаа хариуг УИХ-ын чуулганд сонсож, хэлэлцүүлэхээр “оочероо” хүлээж байна. Тэд боловсролын бодлого, уул уурхай, металлургийн цогцолборын төсөл, өвөлжилтийн байдал, Дарханы замын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Засгийн газраас авахаар хүлээж буй юм. Энэ долоо хоногт гэхэд л Н.Амарзаяа гишүүний “Монгол Улсын усны нөөц, ус ашиглалт болон уг салбарт баримталж буй бодлогын талаар Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг чуулганы хуралдаанд сонсох төлөвлөгөөг баталсан. Хоёр долоо хоногийн өмнө энэ сэдвээр Ерөнхий сайдын мэдээллийг чуулганаар сонсох байсан ч гишүүдийн “шоутай” давхцаад талаар болсон юм. ■

МОНГОЛ АЯЛАЛ КОМПАНИЙН АЯЛЛЫН ХУВААРЬ

№	Аяллын чиглэл	Аяллын хоног	Аялал гарах өдөр
1.	Итгэлт Хамба-Улаан-Үүдийн аялал	3 шөнө, 4 өдөр	01.23, 01.30
2.	Дубай-Истанбул хотын аялал	7 шөнө, 8 өдөр	01.16, 01.30
3.	Манжуур хотын аялал	5 шөнө, 6 өдөр /газар/ 3 шөнө, 4 өдөр /онгоц/	02.13
4.	Бээжин хотын аялал	6 шөнө, 7 өдөр /газар/ 4 шөнө, 5 өдөр /онгоц/	02.13, 02.20
5.	Хөх хот-Ордосын аялал	6 шөнө, 7 өдөр	02.14, 02.21
6.	Эрхүү хотын аялал	5 шөнө, 6 өдөр	01.23, 01.30, 02.6, 02.19
7.	Бали арлын аялал	5 шөнө, 6 өдөр	01.21
8.	Жининь-Хөх хотын аялал	5 шөнө, 6 өдөр	Нэг удаа 30-аас дээш хүнтэй групп аялал
9.	Тайланд улсын аялал	4 шөнө, 5 өдөр	01.22, 02.8, 02.15, 02.22
10.	Вьетнам улсын аялал	5 шөнө, 6 өдөр	02.8, 02.15, 02.22
11.	Шанхай хотын аялал	7 шөнө, 8 өдөр /газар/ 5 шөнө, 6 өдөр /онгоц/	02.6, 02.21

Цагаан сарын аяллын хуваарь

1.	Дубай-Истанбул хотын аялал	7 шөнө, 8 өдөр	02.20
2.	Тайланд улсын аялал	4 шөнө, 5 өдөр	02.22
3.	Хайнань арлын аялал	9 шөнө, 10 өдөр /газар/ 7 шөнө, 8 өдөр /онгоц/	02.20
4.	Эрхүү хотын аялал	5 шөнө, 6 өдөр	02.22
5.	Манжуур хотын аялал	8 шөнө, 9 өдөр	02.20
6.	Бээжин хотын аялал	6 шөнө, 7 өдөр /газар/ 4 шөнө, 5 өдөр /онгоц/	02.22
7.	Вьетнам улсын аялал	5 шөнө, 6 өдөр	02.21
8.	Тэнгэрийн хаалганы аялал	9 шөнө, 10 өдөр /газар/ 6 шөнө, 7 өдөр /онгоц/	02.20
9.	Усан онгоцны аялал	10 шөнө, 11 өдөр	02.22



С.Шаарийбуу

Ерөнхийлөгчтэй дахин уулзах хүсэлтээ илэрхийллээ

Тэрбээр сэтгэл санаа, эрүүл мэндэд учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр Малайзын Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, нотлох баримтуудаа шинээр бүрдүүлэх шаардлагатай болоод байгаа юм

Т.Намуунболор, ЗГМ сонин

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Австралийн Холбооны Улсад болж буй Ази, Номхон далайн орнуудын парламентын 28 дугаар чуулганд оролцох үеэрээ Малайзын парламентын дэд дарга Дато Мохд Рашид Хаснотой уулзжээ. Уулзалтаар Монгол Улсын иргэн Ш.Алтантуяагийн амь насыг Малайзад хөнөөсөн хэргийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхийг хүсэн “Манай иргэний амь насыг хөнөөсөн жигшүүрт хэрэг гараад цөөнгүй жил болж байна. Хэргийг хугацаа алдалгүй эцэслэн шийдвэрлэх ёстой гэж бид үзэж байна. Үүнд түлхэц үзүүлэх зорилгоор хоёр орны парламент хамтарсан ажлын хэсэг байгуулж, ажиллах саналыг тавьж байна” хэмээжээ.

Дээрх хэрэг гарснаас хойш 14 жил өнгөрч байна. Энэ хугацаанд хэргийг хааж, алуурчдад оноосон цаазын ялыг хүчингүй болгож, Нажиб Разак сонгуульд ялагдаж, олон үйл явдлууд өрнөсөн. Талийгаачийн аав С.Шаарийбуу УИХ-ын дарга Г.Занданшатарыг Гадаад харилцааны сайдаар ажиллаж байх үед түүнээс энэ хэрэгт анхаарал хандуулахыг хүсэж байсан. Харамсалтай нь С.Шаарийбууг энэ хэргийн араас 13 жил цөхрөлтгүй хөөцөлдөхөд ямар ч төрийн өндөр албан тушаалтан хүсэлтийг нь харгалзаж үзээгүй юм. Харин өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга түүнийг анх удаа

хүлээн авч уулзаж, Малайз улсад захидал илгээн иргэнийхээ амь насыг нэхсэн. Гэвч шүүх хурал он дамнан үргэлжилж, одоог хүртэл хэргийн ээдрээ эцэс болоогүй байна.

байсан. Ерөнхийлөгч Х.Баттулга намайг анх удаа хүлээн авч, уулзаж, иргэнийхээ амь насыг нэхэн Малайз улс руу захидал илгээсэн. Одоо хэргийн нөхцөл байдал өөрчлөгдсөн. Иргэний хэр-



Учир нь аллага үйлдсэн этгээд хэргийн захиалагчийг илчилснээр шалгалтын ажиллагааг үргэлжлэн явуулж, Нажибыг гэм буруутай гэдгийг тогтоох шаардлага тулгарсан. Мөн С.Шаарийбуу өнгөрсөн хугацаанд өөрт болон ар гэрт нь учирсан сэтгэл санаа, эрүүл мэндэд учирсан хохиролыг нөхөн төлүүлэхээр Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч Эрүүгийн хэрэгт бүрдүүлсэн баримтуудыг Малайз улс Иргэний хэрэгт хэрэгсэхгүй гэж үзсэн нь хэргийг улам бүр сунжруулж байна. Улмаар Иргэний хэргийн шүүх ажиллагаанд зориулан нотлох баримтуудыг шинээр бүрдүүлэхэд асар их мөнгө, цаг хугацааны бэрхшээл тулгарч буй.

С.Шаарийбуу гуайтай холбогдож энэ талаар тодруулахад “Би төрийн өндөр албан тушаалтнуудад удаа дараа хандаж байсан боловч харгалзан үздэггүй

гийн ажиллагаа явагдаж байгаа. Гэвч Эрүүгийн хэрэгт авагдсан баримтыг Иргэний хэрэгт хэрэглэж болох тухай Английн хуульд өөрчлөлт орсон ч Малайз улс түүнийг хэрэглэхгүй гэдгээс үүдэн бүх баримтыг дахин бүрдүүлэх шаардлага тулгарлаа. Үүнд асар их цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардагдаж байна. Би Ерөнхий сайд У.Хүрэлсүхтэй уулзахаар удаа дараа хүсэлт илгээсэн боловч, туслахууд нь уулзуулаагүй. Би Ерөнхийлөгчтэй дахин уулзах хүсэлт гаргасан. Намайг хүлээн авч уулзах болов уу хэмээн итгэж байна” хэмээсэн юм.

Сонгуулийн тов ойртсон энэ өдрүүдэд төрийн удирдлагууд хэрэгсэхгүй байсан асуудалдаа ч анхаарал хандуулж эхэлсэн нь сайшаалтай. Ерөнхийлөгч иргэн С.Шаарийбуутай дахин уулзаж, хэрэг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх эсэхийг харах л үлдээд байна. ■

Yu ve yu ve Америкийн Active Rock чартын шилдэг аравт багтлаа

The Nu хамтлагийн Yu ve Yu ve дуу Америкийн Active Rock чартын топ аравт багтсан байна. Энэ нь гадаад хэл дээрх уран бүтээл тус чартанд орж буй анхны тохиолдол бөгөөд ямар ч рок хамтлагийн хувьд том амжилтад тооцогдох юм. Тус

чартыг алдарт Bad Wolves хамтлагийн Killing me Slowly, Ozzy Osbourne-ийн Under the graveyard зэрэг уран бүтээл тэргүүлсэн байна. Active Rock чарт нь АНУ болон Канадын радио чарт бөгөөд хамгийн шилмэл рок бүтээлүүд тус сувгаар эгшиглэдэг. ■



Чулуун царгил хөгжмийг соёлын өвөөр бүртгэлээ



Монгол Улсын биет ба биет бус соёлын өвийн үндэсний бүртгэлийг шинэчлэн баталжээ. Тус бүртгэлд Баянхонгор аймгийн хүүхдийн “Тэмүүжин” театрын “Чулуун царгил” хөгжим тоглох урлаг багтсан байна. Уг хөгжмийг Баянхонгор аймгийнхан олны хүртээл болгон хөгжүүлж, сум бүр Чулуун царгилын чуулгатай болж буй бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид идэвхтэй суралцаж байна. Хангайн

талд ийм чулуунууд байдаггүй, байсан ч битүү дуутай. Харин говийн чулуу царгилж дуугардаг учраас чулуун царгил гэдэг байна. Уг хөгжмийн зэмсэг нь байгалийн дуу авиа гаргадаг учраас хүүхдийн боловсролд эерэг нөлөө үзүүлдэг аж. Нэмж сонирхуулахад 1950-аад оны үеэс Баянхонгор аймгийн Соёлын ордныхон Түйн голоос түүсэн чулуугаараа ардын дуу, бие биелгээний ая дангуудыг эгшиглүүлдэг байжээ. ■

Багш нарыг хангалттай бэлтгэхгүй бол өнөөдрийн ачаалал

Б.Гандолгор, ЗГМ сонин

Монгол Улсын хувьд өнөөдөр боловсролын салбарын хөгжил хамгийн ээдрээтэй байна. Сургуулийн хүрэлцээ, хангамж тааруу, багш нарын ур чадвар дутмаг, сургалтын чанар сул, сурах бичгийн хангамж муу хэмээн байнга шүүмжлүүлдэг. Гэсэн хэдий ч дорвитой өөрчлөлт, ахиц дэвшил гардаггүй. Ерөнхий боловсролын зарим сургуулиуд нь гурван ээлжээр хичээллэдэг, нэг багшид 50-60 хүүхэд ногддог гээд ачаалал өндөр байгаа юм. Өнөөгийн нөхцөл байдлыг 20 жилийн дараа харьцангуй өөр болж сайжирна гэсэн хүлээлт ард түмэнд байна. Тиймээс 2030 он гэхэд боловсролын салбарт ямар ахиц дэвшил гарсан байх бол гэдгийг сонирхлоо.

БСШУСЯ, Азийн хөгжлийн банк хамтран 2030 онд боловсролын салбарын чанар хүртээмж ямар байх талаар таамаг, төсөөллийн тайлан гаргажээ. Тус тайланд дурдсанаар сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог төгөлдөржүүлэх, нэг багшид оногдох хүүхдийн тоог 25 хүртэл бууруулах, сургуулийн өмнөх боловсролд нийт хүүхдийн 80 хувийг хамруулах зорилт тавьжээ. Мөн 2030 он гэхэд сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоог 20 хүртэл бууруулж, нийт хүүхдийн 90 хувийг сургуулийн өмнөх боловсрол хамруулахаар төлөвлөжээ. 2030 он хүртэлх таамаглалаас үзвэл цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо огцом нэмэгдэхээргүй дүр зураг ажиглагджээ. Харин ЕБС-ийн бага ангийн сурагчдын тоо 18 хувиар, дунд болон ахлах ангийн нийт сурагчдын тоо 2018 оныхоос 71 хувиар нэмэгдэх төлөвтэй байгаа аж. Мөн дээд боловсрол эзэмших залуусын тоо 46 хувиар, МСҮТ-д суралцагсадын тоо 42 хувиар өсөх таамаг харагджээ.

Үүнтэй уялдан дунд болон ахлах ангийн түвшинд мэргэжлийн хичээл заах багшийн тоог



Дараагийн 20 жилд улсын хэмжээнд шинээр 31284 багш бэлтгэх шаардлага тулгарч байна

БАЯНЗҮРХ, СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРГҮҮДЭД 2030 ОНООС ӨМНӨ 1200 ХҮҮХДИЙН СУУДАЛТАЙ 60 ГАРУЙ СУРГУУЛЬ БАРЬЖ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ГАРААД БАЙГАА АЖ. ТҮҮНЧЛЭН ХӨВСГӨЛ АЙМАГ 15 СУРГУУЛЬ ШИНЭЭР АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ ХЭРЭГТЭЙ ГЭСЭН СУДАЛГАА ГАРЧЭЭ.

нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. 2030 он гэхэд манай боловсролын салбарт ажиллах нийт багшийн тоо 50 мянга гаруй


болох төлөв харагдаж буй юм. Гэхдээ багш нарыг хүртээмжтэй бэлтгэж чадахгүй бол нэг багшид ногдох хүүхдийн тоо өнөөгийн түвшинтэй ижил байна гэж дүгнэжээ. Бага ангийн 5158 багш шинээр бэлтгэх хэрэгцээ гарч байгаа бол монгол хэл, уран зохиолын 3838, математикийн 2433, мэдээлэл технологийн 691, физикийн 1221, биологийн 1332, хими 1408, газарзүйн 860, түүх 1171, нийгэм судлал, иргэний боловсрол 2133, дүрслэх урлаг, зураг зүй технологи 3181, хөгжмийн 1633, биеийн тамир 2467, эрүүл мэндийн 1141, англи хэлний 1998, орос хэлний 619 гээд нийт 31284 багш шинээр бэлтгэх шаардлага тулгарч байна. Мөн шинээр цөөнгүй сургууль барих хэрэгцээ үүсэж буй. Тухайлбал, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд 2030 оноос өмнө 1200 хүүхдийн суудалтай 60 гаруй сургууль барьж ашиглалтад оруулах хэрэгцээ гараад байгаа

аж. Түүнчлэн Хөвсгөл аймаг 15 сургууль шинээр ашиглалтанд оруулах хэрэгтэй гэсэн судалгаа гарчээ.

Уг судалгаа таамгийг гаргахдаа

санхүүгийн зардлын хэмжих нэгжийг ам. доллараар хийсэн бөгөөд ханшийн савлагаа нь монгол төгрөгтэй харьцуулахад бага байна хэмээн тооцоолжээ.

ЕБС-Д СУРАЛЦАГСДЫН ТОО 71 ХУВИАР НЭМЭГДЭНЭ



ЭЛСЭЛТИЙН БАЙДАЛ:

Бага анги 2020 онд 371141, 2030 онд 403921

Дунд анги 2020 онд 233818, 2030 онд 311459

Ахлах анги 2020 онд 104024, 2030 онд 191275

ЗГМ СОНИН

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Ерөнхий эрхлэгч
Баатарын Дуламхорлоо
Зөвлөх
Шатарбалын Даваадорж
Орлогч эрхлэгч
Лхагважавын Сугармаа
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ДУГААРЫН УДИРДАГЧ

Э.Батцэцэг
ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА
Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал
INFO@ZASAG.CO
Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

10 жилийн дараа буурахгүй



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

ЕБС-ИЙН БАГА АНГИЙН СУРАГЧДЫН ТОО 18 ХУВИАР, ДУНД БОЛОН АХЛАХ АНГИЙН НИЙТ СУРАГЧДЫН ТОО 2018 ОНЫХООС 71 ХУВИАР НЭМЭГДЭХ ТӨЛӨВТЭЙ БАЙГАА АЖ.

2030 он гэхэд боловсролын салбарт зарцуулах зардлын хэмжээ гурав дахин өснө гэж тооцоолсон байна. Гэхдээ дэлхий дахинд өрнөж буй технологийн хувьсал манай улсын боловсролын салбарт хэрхэн тусгалаа олох нь тодорхойгүй байгаа юм. Одоогоос 10 жилийн дараа ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн агуулга хэрхэн өөрчлөгдөх, ямар шинэ дэвшил гарах талаар уг тайланд нарийвчлан тусгаагүй байна. Энэ нь хүмүүст хуучны заах арга барилаасаа салж чадахгүй байх вий гэсэн эргэлзээ төрүүлж буй. Мөн шинээр ямар хичээл үзэж судлах, сургалтын шинэ технологийг хэрхэн ашиглах бол гэдэг талаар тодорхой таамаг одоогоор салбарын яамнаас гаргаагүй байна. Тэгэхээр шинэ зууны технологийн эринд бидний хойч үе юу үзэж судлах нь тун бүрхэг байгаа юм. Уг нь боловсролын салбарын бодлого чиглэл нь тодорхой байж улс орон хөгжих учиртай. Шинэ зууны мэдлэг боловсролтой иргэдийг бэлтгэхэд ихээхэн анхаарах шаардлагатай билээ. Хойд хөрш багш нарын нийгмийн асуудлыг нэн түрүүнд шийдэж, иргэдээ боловсролтой болгох бодлого барьж байна. Харин манай улсын боловсролын салбар өнгөрсөн жилүүдэд уруудаж ирснээс өөдөлсөнгүй. Тиймээс боловсролын салбарын хөрөнгө санхүүжилтийг сайжруулж, үр хойчоо боловсролтой иргэн болгоход одооноос анхаарахгүй бол дэлхийн хөгжлөөс хэдэн мянган бээрийн цаана хоцрох гээд байгааг холбогдох байгууллага нь ухаарах цаг болсныг сануулахад илүүдэхгүй болов уу. ■

ЗГМ: ТОДРУУЛГА

Д.Мандах: 2030 он гэхэд манай сургууль 23000 багш бэлтгэнэ

Судалгаанаас харахад 2030 он гэхэд Монгол Улсын хэмжээнд 31000 гаруй багш шинээр бэлтгэх шаардлагатай байгаа аж. Энэ талаар МУБИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мандахаас тодрууллаа.



-2030 он гэхэд ерөнхий боловсролын 31000 гаруй багш шинээр бэлтгэх шаардлага үүсээд байгаа юм байна. Танай сургууль энэ төлөвлөгөөг биелүүлж чадах уу. Жилд хэчнээн багш шинээр бэлтгэж байгаа вэ?

-Манай сургуулийн 100 жилийн ой удахгүй болно. Жилд дунджаар 1000 гаруй багш бэлтгэж байгаа. Өнгөрсөн хугацаанд 80 орчим мянган багш бэлтгэжээ. Сүүлийн жилүүдэд боловсролын хүртээмжид илүү анхаарч ирлээ. Хүүхдүүдийг тухтай орчинд сурч боловсрох эрхээр хангахаар ажиллаж байна. Бүх төрлийн дугуйлангийн байраар хангахад анхаарч жилд 30 орчим сургууль, цэцэрлэг ашиглалтад оруулж байгаа. Манай сургууль 42 мэргэжлээр, жилдээ 2800 орчим багш боловсон хүчин бэлтгэж байна. Бүх элссэн оюутнууд бүгдээрээ сургуулиа төгсдөггүй. Тэдний 80 орчим хувь нь сургуулиа төгсдөг. Энэ хүчин чадлаараа ирэх 10 жилд ажиллаж чадвал 2030 он гэхэд 20 гаруй мянган багш бэлтгэх боломжтой. Манайхаас өөр багш бэлтгэдэг сургууль бий. 90 гаруй хувийн сургуулиас 40 нь цэцэрлэг, бага ангийн

багш мэргэжилтэн бэлтгэдэг боллоо.

-Багш нарын ур чадварт хэр дэвшил гарах вэ. Ерөнхий боловсролын сургалтын чанар ирэх 10 жилд хэр сайжрах бол?

-Багшийн ур чадвар гэж ярихаар олон зүйл хөндөгдөнө. Дээхнэ үед сонгоны оюутнуудыг түлхүү элсүүлдэг байлаа. Дунд сургуульд байхаасаа багш болно гэж зорилгоо тодорхойлсон хүүхдүүд илүү сайн суралцдаг. Сайн багш бэлтгэхийн тулд элсэлтийн шалгалтандаа өндөр оноо авсан хүүхдүүдийг Засгийн газрын 100 хувийн тэтгэлгээр сургадаг болсон. 750 оноо авсан бол 100 хувь, 650 оноотойг нь 50 хувийн тэтгэлгээр сургаж байна. Мөн 10 гаруй төрлийн тэтгэлгийн

Манай сургууль сайн багш бэлтгэх арга барилаараа Ази тивд өрсөлдөхөөр зорьж байна. Ингэхийн тулд дэлхийн их, дээд сургуулиуд жишигт нийцсэн сургалтын системийг нэвтрүүлсэн.

хөтөлбөр хэрэгжиж буй учраас багш болох сонирхолтой хүүхдүүдийн тоо нэмэгдэж байгаа. Манай сургууль сайн багш бэлтгэх арга барилаараа Ази тивд өрсөлдөхөөр зорьж байна. Ингэхийн тулд дэлхийн их, дээд сургуулиуд жишигт нийцсэн

сургалтын системийг нэвтрүүлсэн. Онлайн сургалтын чиглэлээр нэлээд хөгжиж байгаа. Хичээл ажиглалтын системтэй боллоо. Тухайн багшийн хичээлийг бичиж аваад дутагдлыг нь засах талаар зөвлөж байна. 90 минутыг үр дүнгүй өнгөрүүлсэн багшид арга хэмжээ авч байна. Багш хүүхдэд хайртай байх ёстой гэсэн шалгуур тавьдаг болж байгаа. Хүүхдийг хүн болгож төлөвшүүлэхэд багш чухал үүрэгтэй гэдгийг үргэлж л ярьж хэлдэг. 2014 оноос хойш ажил дээр гарсан багш нартай холбоотой ажиллаж байна. Мөн мэргэжлээр ажиллаж байна уу үгүй юу гэдэг талаар тандалт судалгаа хийдэг. ■

ЗГМ: ИНФОГРАФИК



Нийт зардал **2020 онд \$288 мянга, 2030 онд \$725 мянган ам.доллар** зарцуулах тооцоо гаргажээ.

Сургуулийн насны хүн амын тоо

Түвшин	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
СӨБ	308213	312052	315128	322460	326240	324655	322659	319721	317055	314949	313729
ЕБС	734991	770085	805629	835460	865749	891865	910630	923468	939660	949353	954476
Дээд	185184	179695	174471	173074	176312	189079	208872	233129	250939	265730	277345
МБСТ	38497	39235	40382	41798	43352	45438	47113	48885	50829	49895	54527

ДЭЛХИЙД

Хятад даяар гурван тэрбум аялал айсуу нь вирусийн тархалтыг ихэсгэх аюултай


Г.Очирбат, ЗГМ сонин

Төв Хятадад дэгдсэн шинэ вирус дөрөв дэх хүнийхээ амийг авч, халдвар эмнэлгийн ажилтнуудад дамжсан нь билгийн тооллын сар шинийн баярын амралтаар аялан зорчих гэж буй сая сая хүмүүсийн дунд SARS төст өвчин тархах вий гэсэн айдас үүсгэв.

Шинэ өвчин үүсгэгч таамаглаж байсан шиг зөвхөн мал амьтнаас хүнд бус, хүнээс хүнд дамждаг болохыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) тогтоогоод байна. Одоогоор эмнэлгийн 15 ажилтанд вирус халдварласнаас нэгийг нь биеийн байдал муу байгааг БНХАУ-ын төрийн мэдээллийн Шиньхуа агентлаг мэдээлэв.

Шинэ вирус нь 17 жилийн тэртээ 800 орчим хүний амийг авсан SARS буюу амьсгалын замын цочмог хурц үрэвсэлтэй нэг төрөл болж буй учраас эрүүлийг хамгаалах салбарын ажилтнуудад маш эрсдэлтэй. Хэд хэдэн улсад илрээд буй шинэ өвчин хүнээс хүнд хялбар дамждагийг олж тогтоосон нь түгшүүрийг бүр ихэсгэснийг Австралийн Үндэсний Их Сургуулийн анагаах ухааны профессор Санжаяа Сенанаяке тайлбарласан юм. Урьд дэгдсэн SARS-тай харьцуулахад “одоогоор үхлийн тоо бага байгаа нь сайн хэрэг” хэмээн профессор өгүүлэв.

Шинэ корона вирусийн халдвараар дөрөв дэх хүн нас барсныг өвчний голомт төв Хятадын Ухань хотын эрүүлийг хамгаалах албаны хүмүүс мэдэгдлээ. Даралт ихэсдэг, чихрийн шижин, зүрхний титэм судасны өвчтэй 89 настай хөгшин энэ сарын 18-нд эмнэлэгт хэвтсэнийхээ маргааш нь өнгөрчээ. Уханьд өдгөө өвчний халдвартай 200 орчим хүнийг бүртгээд байна. Халдвар мөн Бээжин, өмнөд



Хятадын Гуандун мужид ч илэрчээ. Мөн Ази, Номхон далайн бүсийн Өмнөд Солонгос, Тайланд, Японд ч Уханьд аялаад ирэгсдийн дундаас өвчний тохиолдол бүртгэсэн юм.

Хятадад халдварын тохиолдолд долоо хоногийн эцэс, амралтын өдрүүдэд ихэссэнтэй уялдан дэлхий даяар эрүүлийг хамгаалах байгууллагууд халуурах, ханиалгах зэрэг вирусийн халдварын шинж тэмдэг бүхий тохиолдлыг нарийвчлан хянаж шалгадаг боллоо. Хэдхэн хоногийн дараа болох билгийн тооллын сар шинийн баярын амралтыг ар гэртээ тэмдэглэхээр Хятад даяар гурван тэрбум аялал болох гэж байгаа нь вирусийн тархалтыг ихэсгэх аюултай. Шинэ корона вирусийг Хятадын эрүүлийг хамгаалах комисс SARS мөн багтдаг халдварт өвчний “В” ангилалд хамааруулахаар шийдвэрлэв. Тус улс холер, тахал зэрэг онц ноцтой өвчний үед авдаг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна.

ЗӨВЛӨМЖ

- Ямар нэгэн амьсгалын замын өвчлөл, ханиадтай хүнээс хол байх (Манай улсын хувьд одоогоор гадаадын иргэд өвчний сэжиг бүхий хүн)
- Эмч нарын зөвлөмжийн дагуу гараа тогтмол, зөв угаах
- Мал, далайн гаралтай амьтныг бэлтгэдэг, боловсруулаагүй түүхий эдийг худалдаалдаг газруудаас хол байх (Хятад улсын хувьд өгсөн зөвлөмж)
- Ханиад, томуу болон амьсгалын замын ямар нэгэн өвчин туссан хүн бусдад халдаахгүйн тулд эрүүл ахуйн дэглэмийг чанд сахих, амны хаалт зүүх (шүлс, нусаа ил задгай хаяхгүй, амны цаас, алчуур байнга хэрэглэж байх)
- Эрүүл мэндийн байгууллагууд халдвар, ариутгалын дэг журмыг чанд сахин мөрдөх

Эх сурвалж: ДЭМБ

МОНГОЛД

Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа учраас мэдээлэл өгөх боломжгүй

тавьж, ямар зохицуулалт хийж байгаа талаар албаны хүмүүсээс тодруулахад хариулт өгөх хүн олдсонгүй. Хятадад гараад байгаа уг өвчин манай улсад гарах боломжтой эсэхийг ХӨСҮТ-өөс тодруулахад “Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа учраас мэдээлэл өгөх боломжгүй” хэмээн хариулахаас татгалзсан юм. Сүх далайтал үхэр амар гэгчээр манай улсад бүртгэгдээгүй хэмээн тайван байгаа эрүүл мэндийн салбарынхан дараа нь амаа барих вий.

ХЭДХЭН ХОНОГИЙН ДАРАА БОЛОХ БИЛГИЙН ТООЛЛЫН САР ШИНИЙН БАЯРЫН АМРАЛТЫГ АР ГЭРТЭЭ ТЭМДЭГЛЭХЭЭР ХЯТАД ДАЯАР ГУРВАН ТЭРБУМ АЯЛАЛ БОЛОХ ГЭЖ БАЙГАА НЬ ВИРУСИЙН ТАРХАЛТЫГ ИХЭСГЭХ АЮУЛТАЙ.

Г.Санжааханд, ЗГМ сонин

Коронавирусийн халдвар хүнээс хүнд амьсгалын болон ахуйн замаар халддагийг тогтоолоо. Урд хөрштэй хил залгаа оршдог, бараа бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг импортлодог улс орны хувьд шинэ төрлийн вирус дэгдэхгүй гэх баталгаагүй.

Өнөөдөр ДЭМБ-ын Онцгой асуудлын Хороо хуралдаж, энэхүү өвчний талаар Олон улсын түвшинд онц байдал зарлах эсэхийг шийдвэрлэх юм байна. Гэтэл эрүүл мэндийн байгууллагууд сэрэмжлүүлэг мэдээллийг хангалттай хүргэхгүй байгаагаас иргэдийн дунд коронавирүсээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл дулимаг байна. БНХАУ-ын Эрээн хотыг зорих иргэдийн тоо нэмэгдсээр галт тэрэгний билет ч олдохоо байлаа. Сар шинийн баяр дөхсөн энэ үед цаашид хөл хөдөлгөөн улам ихсэх нь тодорхой байна. Тиймээс үүнд хэрхэн хяналт

ДЭМБ-аас гаргасан зөвлөмж дээр үндэслэн ЭМЯ-наас сэрэмжлүүлэг гаргасан байв. Сэрэмжлүүлэгтээ “Мал, далайн гаралтай амьтныг бэлтгэдэг, боловсруулаагүй түүхий эдийг худалдаалдаг газруудаас хол байх” хэмээн “монголчилсон” байв. Монголын нөхцөлд нийцэхгүй ийм зөвлөмж гаргачихаад дараа нь сэрэмжлүүлээд байхад иргэдийн буруутай үйлдлээс болсон хэмээн буруугаа бусдад тохож, ханиаданд дарлуулдаг шиг нөхцөл байдал үүсэх эрсдэл ойрхон байна. ■

ЗАРЛАЛ

5863961 регистрийн дугаартай
“Эпато анарваан”
ХХК-ийн нэрийг
“Мөнх гийх эрхэс”
ХХК болгож
өөрчиллөө.

Агаарын дүүжин тээвэр ирэх онд ашиглалтад орно

Агаарын дүүжин тээвэр хэзээ ашиглалтад орох талаар нийслэлийн Засаг дарга С.Амарсайханаас тодрууллаа.

-Агаарын дүүжин тээвэр хэзээ ашиглалтад орох вэ?

-Агаарын дүүжин тээврийн ажлыг бид ирэх дөрөвдүгээр сард эхлүүлэхээр төлөвлөж байна. Хугацаандаа эхэлсэн тохиолдолд 2021 оны зургаадугаар сард эхний маршрут буюу Баянхошуу, Ханын материал болон III, IV дүгээр

хороолол чиглэлд явна.

-Хүчин чадал, зорчих үнийн хувьд ямар байх бол?

-Одоо нийтийн тээвэрт мөрдөгдөж байгаа үнийн хэмжээнд байлгаж, иргэдэд аль болох боломжтой хэлбэрээр үнээ тогтооно. Цагт 3000 хүн тээвэрлэх хүчин чадалтай гэдэг нь өдөр дунджаар 40 мянга орчим хүн тээвэрлэнэ гэсэн үг.

-Аюулгүй байдлыг хэрхэн хангах тал дээр тайлбар өгөхгүй юу?

-Агаарын дүүжин тээвэр бол бусад тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад хамгийн аюулгүй хэрэгсэл юм. Энэ тээвэр нь анхнаасаа цас ихтэй, уулархаг газруудад зориулсан технологи. Дэлхийн олон хот үүнийг нийтийн тээвэрт ашиглаж байгаа бөгөөд цаг агаарын хувьд -50, +50 градуст хэвийн ажиллана. Мөн дотоод гадаадын олон мэргэжлийн хүн бүх талаас нь судалж аюулгүй байдлыг нь хангасан учраас бид хэрэгжүүлж болно гэж үзэж байгаа юм. ■



НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Баян, ядуугийн ялгаа нэмэгдэх хэрээр дундаж давхарга хумигдсаар

Нийгмийн давхарга хооронд шилжих боломжийг нэмэгдүүлснээр дэлхийн эдийн засаг дараагийн 10 жилд таван хувиар илүү өсөх тооцоо гарчээ

Г.Баярсайхан, ЗГМ сонин

Хүмүүс нийгэм, эдийн засгийн байдал, гарал үүслээс үл хамааран амьдралаа дээшлүүлэх боломж бүхий нийгэм бий болгох нь асар их ашиг тустай төдийгүй эдийн засгийн өсөлтийг хэдэн зуун тэрбум ам.доллараар нэмэгдүүлэх боломжтой болохыг Дэлхийн эдийн засгийн чуулганд оролцогчид онцолж байна. Нийгмийн давхарга хооронд шилжих боломж буюу Social Mobility-г 10 хувиар нэмэгдүүлснээр дэлхийн эдийн засаг дараагийн 10 жилд таван хувиар илүү өсөх тооцоо гаргасан тухай чуулганы шинэхэн тайланд дурджээ. Нийт 82 орныг харьцуулсан энэхүү судалгаагаар Дани, Норвег, Швед, Финланд, Исланд зэрэг Скандинавын хойгийн орнууд тэргүүн эгнээнд жагссан байна. Нийгмийн давхарга хооронд шилжих боломжийг сайжруулснаар хамгийн их өгөөж хүртэх орноор БНХАУ, АНУ, Энэтхэгийг нэрлэжээ. Энэхүү үзүүлэлтийг сайжруулахын тулд илүү шударга цалингийн систем, нийгмийн халамж, насан туршийн боловсрол, ажлын таатай нөхцөл гэсэн дөрвөн зүйлд голлон анхаарах шаардлагатайг дурдсан байна.

Хэрэв улс орнууд Social Mobility-г 10 пунктээр нэмэгдүүлж чадвал ирэх арванд ДНБ нь 4.4 хувиар өсөх тооцоог мөн гаргажээ. Эндээс хамгийн их өгөөж хүртэх нь өмнөд хөрш Хятад бөгөөд тус улсын эдийн засаг жилд 103 тэрбум буюу ирэх арванд бараг нэг их наяд ам.доллараар нэмэгдэх тооцоо байна. Тус улс жил бүр 10 сая орчим хүнийг ядуурлаас гаргаж буй нь нийгмийн давхарга хооронд

шилжих боломжийг нэмэгдүүлсэн сонгодог жишээ юм. Гэхдээ бүхэлд нь харвал давхарга хоорондын шилжилт тийм ч таатай үр дүн үзүүлэхгүй байх магадлалтай. ДЭЗЧ-д зориулж хийсэн судалгаагаанд оролцогчдын 44 хувь нь ирээдүйн төлөв байдал өнөөгийн ээж, аавынх нь нөхцөл байдлаас дор байна гэж үзэж буйгаа илэрхийлжээ.

Харамсалтай нь, энэ тайланд Монгол Улс багтсангүй. Өөрөөр хэлбэл, давхарга хооронд шилжих боломж Монголд хэр байдаг талаар нарийн тоо баримт алга. Тиймээс багцаалдсан, таамагласан л мэдээлэл гаргах боломжтой. Гайхалтай нь, эдүгээ Монголын дундаж давхарга нийт өрхийн 30-90 хувийг эзэлж буй гэсэн судалгаа байна.

Эзлэх хувь ийм хол зөрүүтэй байгаа нь тооцох аргачлалаасаа шалтгаалдаг аж. ERI буюу Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс манай улсын нэг хүнд ногдох өдрийн орлогыг хамгийн сул хэмжүүрээр тооцоход дундаж давхаргын хэмжээ 85 хувьд хүрч байв. Харин уг аргачлалаа дэлхийн жишигтэй дүйцүүлж, орлогын өндөр үзүүлэлтээр хэмжвэл манай дундаж давхаргын эзлэх жин 30 хувь болтлоо буурсан байгаа юм.

Нэг өдрийн орлогын тооцооноос хамаарч ийм эрс тэс дүн гарч байгаа нь энэ.


Уг нь дундаж давхарга гэдэг улс орны хөгжлийг илтгэдэг гол үзүүлэлт. Учир нь дундаж давхарга ихтэй нийгэмд эдийн засгийн өсөлт илүү байдаг. Скандинавын орнуудад баян, ядуугийн ялгаа маш бага байдаг нь үүнтэй холбоотой. Харин манайд энэ ялгаа улам бүр ихэссээр буйг төрөл бүрийн судалгаанаас харж болно. Тухайлбал, Үндэсний статистикийн



Social Mobility индексээр тэргүүлэгч улс орнууд

Дани	85.2
Норвег	83.6
Финланд	83.6
Швед	83.5
Исланд	82.7
Нидерланд	82.4
Швейцар	82.1
Австри	80.1
Бельги	80.1
Люксембург	79.8

Social Mobility-г нэмэгдүүлснээр хамгийн их өгөөж хүртэх орнууд



хорооноос 2018 онд танилцуулсан судалгаанд нийт хүн амыг хэрэглээгээр нь 10 бүлэгт хуваан үзжээ. Хамгийн чинээлэг хэсгийн нэг хүн сард дунджаар 605.4 мянган төгрөг хэрэглэж байгаа бол хамгийн ядуу бүлгийн хүний сарын дундаж хэрэглээ 78.4 мянган төгрөг байв. Өөрөөр хэлбэл, ядуу бүлгийнхний хэрэглээ чинээлэг иргэдийнхээс 7.7 дахин бага байгаа юм.

Орлогын тэгш бус байдлыг илэрхийлдэг жини коэффициент ч тогтмол сөрөг үзүүлэлттэй гарч байна. Уг үзүүлэлт бага байх тусмаа орлогын хуваарилалт тэгш байна гэж үздэг бөгөөд манай улсын хувьд энэ үзүүлэлт 1998 онд 30.3 хувь байсан бол 2016 онд 32.3 хувь болон өсчээ. Ганц хувийн өөрчлөлт улсын эдийн засагт асар чухал нөлөөтэй байдлыг бодолцвол орлогын тэгш бус байдал улам нэмэгдсээр байна гэсэн үг. Үр дүнд нь эдүгээ Монголд 900 мянга буюу нэг сая шахам хүн сард 166 мянга хүрэхгүй төгрөгөөр амьдралаа залгуулж буйг Дэлхийн банкны хийсэн судалгаа харуулсан.

Дэлхийн эдийн засгийн чуулганы тооцоогоор 2030 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутагт дундаж давхаргын

тоо 3.2 тэрбумд хүрч, 2009 оныхоос 6.2 дахин өснө. Энэ үед Хятад, Энэтхэгийн дундаж давхарга дэлхийн эрэлтийг тодорхойлох болно. Харин манай улс Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалдаа 2030 он гэхэд дундаж давхаргыг 80 хувьд хүргэнэ хэмээн төлөвлөжээ. Сэрчихгүй бол сайхан л зүүд гэдэг шиг хэрэв биелдэг бол бид аз жаргалын индексээр тогтмол тэргүүлдэг улс орнуудыг ч давж гарах нь. Дундаж давхаргын эзлэх хувиар дэлхийд тэргүүлдэг Австралид гэхэд энэ үзүүлэлт 66 хувьтай байдаг. Харин бид 80 хувьдаа яаж хүрэх, үүний тулд ямар бодлого хэрэгжүүлэх, үүнд хэдий хэр хөрөнгө зарцуулах талаар ямар ч тооцоо судалгаа алга. Товчхондоо бол цаасан дээрх мөрөөдлийн төлөвлөгөө л байна. Гэхдээ дээр дурдсан шиг орлогын хамгийн сул үзүүлэлтээр тооцоод 80 хувьд хүрлээ гэж зарлаж мэдэх л юм, манай дарга нар. Гэвч иргэдийн бодит орлого, амьжиргааны түвшин арай өөрийг илэрхийлээд байвал ямар ч сайхан тоон үзүүлэлт гаргаж тавиад нэмэргүй.

Нийгмийн давхарга хооронд шилжих боломжийг нэмэгдүүлэх гол үзүүлэлтүүд Монголд ямар

байгааг бодолцож үзье. Цалингийн шударга системээр лав Монгол Улс сүүл хавиар жагсана. НҮБ-аас хийсэн судалгаагаар монголчуудын сарын дундаж цалин 394 ам.доллар бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан 72 орноос 66-д бичигдэх үзүүлэлт юм. Харин дэлхийн дундажтай харьцуулахад 3.5 дахин бага. Ийм нөхцөлд цалингийн шударга систем ярих нь хүмүүсийн уурыг хүргэхээс хэтрэхгүй. Нийгмийн халамжийн тухайд нийт хамрагддаг хүнээр нь тооцвол Монгол бараг дэлхийд тэргүүлэх байх. Дөрвөн монгол хүн тутмын нэг нь ямар нэг халамжид хамрагддаг гэсэн судалгаа ч бий. Гэхдээ халамж хэт хавтгайрсан, зорилтот түвшиндээ хүрдэггүй, хоёрын хооронд амсуулах төдий бага байдаг нь бид халамжийн тогтолцоондоо өөрчлөлт хийх шаардлагатайг харуулж байна. Харин насан туршийн боловсролын үзүүлэлт харьцангуй гайгүй гарах байх. Нийт хүн амын ерөнхий боловсрол эзэмшсэн үзүүлэлтээр бид дэлхийд дээгүүр бичигддэг нь үүний шалтгаан. Гэхдээ орчин цагийн хэрэгцээ шаардлагад нийцсэн боловсон хүчин бэлдэж чадаж байна уу гэвэл асуудал өөрөөр яригдана. Ажлын нөхцөл байдлын тухайд таатай гэж дүгнэхэд нэн хэцүү. Ингээд бодохоор ядуусын эгнээгээ багасгаж, дундаж давхаргыг нэмэгдүүлэх мөрөөдлийн төлөвлөгөөнд дорвитой ахиц дэвшил гарна гэсэн итгэл төрөхгүй л байна. Энэ зуур дэлхий нийт ирээдүйг илүү холоор харж, алсын бодлого төлөвлөгөөгөө хэдийн боловсруулж, тодорхой үр дүнд хүрээд эхэллээ. Хятад улс гэхэд сүүлийн таван жилд 60 сая хүнийг ядуурлаас гаргалаа. Үлдсэн 30 сая ядуу иргэнээ ойрын 2-3 жилд дундаж давхаргад шилжүүлнэ гэж байна. Энэтхэгт хэдийгээр 300 сая хүн нэн ядуу амьдарч байгаа ч сүүлийн таван жилд ядуусын тоо мөн л 50 орчим саяар багассан статистик байна. Харин Монголд баян, хоосны ялгаа улам ихсэж, дундаж давхарга нь ядуусын эгнээ рүү шилжсээр байна. Гэсэн атал ядуурал дорвитой буурах итгэл төрж өгөхгүй байгаа нь хамгийн том эмгэнэл юм даа. ■

ЭДИЙН ЗАСАГ

- ⊖ Д.Сумьяабазар: “Эрдэнэс Тавантолгой Майнинг”-ийн IPO сонгуультай тулах нь → 9
- ⊖ Гадаад өрийн “гамшгаас” болж дефолт зарлах ойрхон байна → 10

- ⊖ Вьетнамд шийтгэл чангарсан нь шар айргийн борлуулалтыг бууруулав → 11
- ⊖ БНХАУ-ын ихэнх мужийн эдийн засгийн өсөлт саарна → 11

ЗГМ: ТОВЧХОН

■ АРИЛЖАА

Монголын Хөрөнгийн бирж мягмар гарагийн үнэт цаасны арилжаагаар 28 компанийн 570,506 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 13 компанийн хувьцааны ханш өсөж, 11 компанийнх буурав.

■ ИНДЕКС

0.32

Хувь. ТОП 20 индекс 0.32 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ 2.6 их наяд төгрөг боллоо.

■ ДУУДЛАГА ХУДАЛДАА

16.5

Сая ам.доллар. Гадаад валютын дуудлага худалдаагаар төв банк 16.5 сая ам.доллар зах зээлд нийлүүлээ.

■ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Харшийн гэрээ” компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал ирэх сарын 26-ны өдөр болно. Энэ үеэр компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах бөгөөд 2020 оны төлөвлөгөөг хэлэлцэн батлах аж. Мөн төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр сонгохоор болжээ.

■ ИПОТЕК

37.7

Хувь. Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 11 дүгээр сарын эцэст 12.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 789.9 тэрбум төгрөгөөр өсжээ. Иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдлийн 37.7 хувийг ипотекийн зээл, 26.3 хувийг цалингийн зээл, 13.3 хувийг жижиг дунд үйлдвэрийн зээл, 10.4 хувийг хэрэглээний зээл, 6.4 хувийг тэтгэврийн зээл, 5.9 хувийг бусад зээл тус тус эзэлж байна.

■ ТӨСӨВ

9.7

Их наяд төгрөг. Татварын нийт орлого 2019 онд 9.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.5 их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 22.1 хувь, нийгмийн даатгалын орлого 21.9 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 13.1 хувь, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 28.8 хувь, онцгой албан татвар 14.4 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 15.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



Дэлхийн эдийн засгийн чуулган нэгдмэл оролцоог чухалчилж байна

Давосын эдийн засгийн чуулганд Ерөнхийлөгч Х.Баттулга анх удаагаа оролцож байна

✎ Б.Баяртогтох, ЗГМ сонин

Дэлхийн эдийн засгийн 50 дахь удаагийн чуулган “Тогтвортой хөгжлийг цогцлоох оролцогч талууд” гэх үндсэн сэдвийн хүрээнд Швейцарын Давос хотноо үргэлжилж байна. Жил бүр дэлхий нийтийн анхаарлын төвд болж өнгөрдөг энэхүү чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга анх удаа оролцож буй. Чуулганы оролцогчдыг дэлхийн улс орнуудын тэргүүн нараас гадна улс төрийн нөлөөтэй зүтгэлтнүүд, бизнесийн топууд бүрдүүлдэг. Дэлхийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн эрхмүүдийн тогтвортой хөгжилд тулгарч байгаа нийтлэг бэрхшээл, сорилтыг хэрхэн даван туулах талаар ярилцдаг, тэр хэрээрээ энэ нь хүн төрөлхтний анхаарлыг хамгийн их татдаг. Цэнхэр гарагийн тулгамдсан

асуудлыг цэгнэн ярилцах энэхүү арга хэмжээнд АНУ-ын төрийн тэргүүн оролцож байна. АНУ Хятадын хооронд жил дамнасан худалдааны маргааныг цэгцлэх хэлэлцээр ид үргэлжилж буй энэ үед ОУВС 2020 оны дэлхийн эдийн засгийн таамгийг шинэчлэн танилцууллаа. Худалдааны дайн өөр олон бэрхшээлийг товойлгон гаргаж мэдэхээр байгааг тус сан анхааруулж, дэлхийн эдийн засагт тодорхой бус нөхцөл байдал давамгайлсаар байгааг тэмдэглэсэн.

Давосын чуулгантай зэрэгцэн ОУВС ээлжит таамгаа зарласан нь чуулганы “уур амьсгал”-ыг илүү ажил хэрэгч болгов. Салбар салбарын тэргүүлэгч 740 гаруй илтгэгчид энэ жилийн тулгамдсан асуудлын шийдлийг хэлэлцүүлэх юм. Дональд Трампас гадна уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг идэвхтэн Грета Тунберг, Европын төв банкны Ерөнхийлөгч, ОУВС-ийн тэргүүн асан Кристин Лагард, ХНБГУ-ын Канцлер

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАНЫ 50 ЖИЛИЙН ОЙ ЭНЭ ОНД ТОХИОЖ БУЙ. АНХНЫ ХУРАЛДААНАА 350-ХАН ХҮНТЭЙ ЭХЛҮҮЛЖ БАЙСАН ТУС ЧУУЛГАН ӨНӨӨДӨР ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН УДИРДАГЧДЫГ БАНК САНХҮҮГИЙН ЕРТӨНЦИЙНХ НЬ ЛИДЕРҮҮДТЭЙ ХАМТ НЭГ ДОР ЦУГЛУУЛЖ, ТЭДНИЙ УУЛЗАХ ТАЛБАР НЬ БОЛООД БАЙНА.

засгийн чуулганы гол сэдэв нь дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн дунд бий болсон худалдааны маргаан байсан. Тэгвэл 2020 онд мөн адил уг сэдэв олон улсын анхаарлын төвд хэвээр байна. Америк болон Хятадын эдийн засаг мэдэгдэхүйц удааширсан нь дэлхий нийтэд багагүй сорилт авчрах нь. Тэдний худалдааны хямралт байдал 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг хойш татаж мэдэхээр байгаа юм. Үүнийг ОУВС онцолсон.

Дэлхийн эдийн засгийн чуулганы 50 жилийн ой энэ онд тохиож буй. Анхны хуралдаанаа 350-хан хүнтэй эхлүүлж байсан тус чуулган өнөөдөр дэлхийн улс орнуудын удирдагчдыг банк санхүүгийн ертөнцийнх нь лидерүүдтэй хамт нэг дор цуглуулж, тэдний уулзах талбар нь болоод байна. Давосын чуулган 26 дахь удаагийн “Болор” шагналын эздээ өчигдөр тодруулж, албан ёсоор чуулга уулзалт эхэлж байгаагаа зарласан. Энэ удаагийн “Болор” шагналын эздээр Америкийн уран бүтээлч Тестер Гейтс, Хятадын бүжиг дэглээч Цзинь Син, Энэтхэгийн жүжигчин Дипика Падукон, мөн Австралийн уран бүтээлч Ленит Уолворт нар тодорсон юм. ■

Ангела Меркель тэргүүтэй зочид оролцож байна.


Нэгдмэл бус хагарал, бутрал, маргаан тэмцэл цаашид олон улсад гүнзгийрсээр байвал энэ нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, санхүүгийн эмзэг байдлыг үүсгэж болзошгүй нь. Тиймээс бодит эрсдэлийг боломж болгон хувиргах яриа, хэлэлцээр энэ өдрүүдэд өрнөнө. Эргэн сануулахад, 2019 оны эдийн

ЗГМ: ИНФОГРАФИК

УУЛ УУРХАЙ

ШИНЖЛЭХ УХААНЫ СУДАЛГААГААР ТЭРГҮҮЛЖ БУЙ УЛСУУД

2018 онд сонин, сэтгүүлд нийтлэгдсэн шинжлэх ухаан, инженерийн судалгааны ажил, нийтлэлүүд



ХУВИАР



Эх сурвалж: National Science Foundation



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

М.Золбоо, ЗГМ сонин

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн охин компани болох “Эрдэнэс Тавантолгой Майнинг” компанийн IPO гаргах бэлтгэл ажил үргэлжилж байгаа бөгөөд сонгуулийн хугацаатай нэлээд тулах төлөвтэй байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдэгдлээ. Өмнө нь гарсан эх сурвалжийн мэдээлэлд дурдсанаар нэг тэрбум орчим ам.долларын IPO-ийг Хонгконгийн хөрөнгийн биржээр дамжуулан энэ оны эхний хагас жилд багтаан гаргах төлөвтэй байгаа юм. Үүнээс гадна “Оюу Толгой” төслийн хэлэлцээг хийх ажлын хэсэг байгуулагдсан байна. Ажлын хэсгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ ахалж, Байгаль

орчин, Аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг уул уурхайтай хамаарал бүхий Төрийн байгууллагууд ажлын хэсэгт багтаж үйл ажиллагаа явуулах юм байна. Удахгүй ажлын хэсэг хуралдана гэж Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдэгдлээ.

Үүнээс гадна Засгийн газар АИ-92 шатахууны үнийг тогтвортой байлгах үүднээс Hedge Fund буюу “Эрсдэлийн сан” байгуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнтэй холбогдуулан Ашигт малтмал, Газрын тосны газар Bdo International компанитай хэджийн гэрээ байгуулахаар ажиллаж байгаа аж. Брент төрлийн газрын тосны үнэ 71 ам.доллараас

дээш болбол зөрүүг нь тухайн импортлогч компаниудад нөхөж өгөх юм байна. Монгол Улсын АИ92 шатахууны хагас жилийн хэрэгцээ буюу 200-аад мянган тонн шатахуун дээр хэдж хийж байгаа талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдэгдлээ. Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам ахалсан төлөөлөл нэгдүгээр сарын 23-нд Москвад очиж, “Роснефть” компанитай 2020 оны шатахууны хангамжийн нөөцийн асуудлаар тохиролцох юм байна. Монгол Улс 2019 онд 1.16 тэрбум ам.долларын нефтийн бүтээгдэхүүн импортлосон талаар Гаалийн ерөнхий газар мэдээлээд байна. Харин газрын тосны экспорт 366.7 сая ам.доллар болжээ. Газрын тосыг “Петрочайна Дачин Тамсаг”, “Доншин” компаниуд экспортолж байгаа юм. ■

Эдийн засаг, бизнесийн мэдээлэл
24 цагаар таны сонорт...

Ж.Чулуунхүү, Монголын дипломат ажилтнуудын үндэсний холбооны ерөнхийлөгч, төлөвлөгч инженер-эдийн засагч, зөвлөх судлаач, докторант

Монгол Улс ардчлалын он жилүүдэд “хандивлагч орнууд”-аас өндөр хүүтэй зээл авч ашигласны өр төлбөр нь 2019 оны эцсийн байдлаар 30 тэрбум ам.долларт хүрчээ.


Дэлхийн ихэнх орон гаднын байгууллагаас зээл, буцалтгүй тусламж авахын оронд үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтөө хангаж байхад манай улс л гадаад өр төлбөрөө жилээс жилд улам нэмэгдүүлсээр байна.

Монгол Улс ОХУ-д төлөх 10 гаруй тэрбум ам.долларын “Их өр”-ийг 97 хувиар хөнгөлүүлж, 250 мянган ам.доллар төлснөөр тэглэсэн. Мөн бусад орны өрийг дотоод нөөц бололцоогоо бүрэн дайчилж, тодорхой үе шаттай төлж дуусгахад биечлэн оролцсон амьд гэрч нь би байна.

Харин 1990 оноос хойших 29 жилийн хугацаанд Монгол Улсын гадаад улсуудаас авсан зээлийн өрийг хугацаа сунгуулах, өрийг өрөөр дарах арга хэрэглэсээр өдгөө 30 тэрбум ам.долларт хүргэсэн нь харамсалтай. Өнөөдөр монгол хүн эхийн хэвлийнээс унахдаа л 10 шахам мянган ам.доллар буюу 28 сая төгрөгийн өртэй болох жишээтэй.

Судалгаанаас үзэхэд Монгол Улсын гадаад өр сүүлийн 10 жилд зургаа дахин өсжээ. Төр, засгаас бодит тооцоо, судалгаа, дүгнэлтэд суурилсан шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол удахгүй гадаад их өрийг төлж чадахааргүй санхүүгийн томоохон хямралд өртөж, Саарал жагсаалтаас гарах биш, харин ч Хар жагсаалт руу нь гулсаж, Монгол Улсын эдийн засаг дефолт зарлах аюул тун ойрхон байна. Төрийн дипломат албанд 50 гаруй жил зүтгэсэн, эдийн засгийн чиглэлээр гадаадад суралсэн, төрийн байгууллагууд болон гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад ажиллаж ирсэн мэргэшсэн төлөвлөгч, инженер-эдийн засагчийн хувиар миний бие 2016-2019 онуудад судалгаанд суурилсан бодит тоо, баримтаар шүүмжилж, санал дүгнэлтээ төр, засгийн удирдлагуудад нэг биш удаа уламжилсан боловч “усанд хаясан чулуу шиг” сураг тасарсанд нь сэтгэл дундуур байдаг.

Дотоод нөөц бололцоогоо дайчилж улсын төсвийн ашиггүй, үрэлгэн зардлыг хэмнэж, алдагдалгүй болгохын оронд гадаад улсууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зээл, буцалтгүй тусламж, төсөл,



Гэрэл зургийг С.Батсайхан

2019 онд гэхэд л гадаад өрийн хэмжээ өмнөх онынхоосоо хоёр тэрбум гаруй ам.доллар буюу 7.8 хувиар өссөн байна

хөтөлбөрийг хэтэрхий шүтэн өрийн дансаа жилээс жилд зузаатгасаар байна. 2019 онд гэхэд л гадаад өрийн хэмжээ өмнөх онынхоосоо хоёр тэрбум гаруй ам.доллар буюу 7.8 хувиар өссөн байна.

ГАДААД ӨР БАРАГДУУЛАХАД ЗАЙЛШГҮЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Иймд нэгэнт хуримтлагдсан их хэмжээний гадаад өрийг хоёр Талын тохиролцсон хугацаанд нь эргүүлэн төлж барагдуулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд дараах санал дэвшүүлж байна. Юун түрүүнд баялаг бүтээгчдээ хөхиүлэн дэмжиж, экспортын барааны нэр төрөл, тоо хэмжээг тууштай нэмэгдүүлэх хэрэгтэй. Замын Үүд, Алтанбулаг, Цагаан нуурын 20 жил дуншиж байгаа чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг


Яамдын орлогч сайд, тэдгээрийн газар, хэлтсийн 10 ажилтны 3-4 нь ахлах зэрэглэлээр цалинждаг, засаг даргын 4-6 орлогч зэргийг цомхотголд нэн түрүүнд оруулах шаардлагатай.

бүлийн эзэмшилд ашиглагдаж байгаа томоохон ордуудыг төрийн өмчид шилжүүлж авах нь зөв юм. Түүнчлэн Баялагийн санг Норвег улсын жишиг, туршлагаар байгуулах, нийгмийн даатгал, тэтгэврийн гаж тогтолцоог яаралтай шинэчлэн өөрчлөх

Монгол Улсын гадаад өр (тэрбум ам.доллар)

Засгийн газрын өр	7.2 тэрбум,
Монголбанкны өр	2 тэрбум,
Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр	20 тэрбум

Монгол Улсын гадаад өр барагдуулах хуваарь



Эх сурвалж: Монголбанк

шаардлагатай байна. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, улсын төсвийн үрэлгэн зардлыг эрс бууруулж, валютын нөөцийг ихээхэн нэмэгдүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна. Банк, санхүүгийн

байгууллагуудын одоогийн мөлжлөгийн схемийг шийдвэртэй өөрчилж, ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд өрийн дарамтаас гаргах зэрэгт төр, засгийн зүгээс онцгой анхаарч, бодит тооцоо, судалгаа, үндэслэлд суурилсан арга хэмжээг шуурхай боловсруулж хэрэгжүүлэхийг

Монголын 3.3 сая иргэдийн эрх ашиг зүй ёсоор шаардаж байна.

Улсын төсвийг аль болохоор хэмнэн үр өгөөжтэй баялаг бүтээх арга хэмжээнд зориулахын оронд батлагдсан тооцоо, судалгаа, ТЭЗҮ, үр ашиг муутай төсөл, хөтөлбөрийг

УИХ-ын гишүүд нь нөгөө л жалга, довны үзэл, хувийн бизнесээ санхүүжүүлэх, дахин сонгогдох гэсэн хувийн ашиг сонирхолдоо хөтөлгөн баталж байна шүү дээ.

ТӨРИЙН АЛБАНЫ ДАНХАР БҮТЭЦ ГИННЕСИЙН НОМД МӨНХРӨХ НЬ

Ард түмний шүүмжлэлийн бай болсоор олон жил болж буй “Гиннесийн ном”-д мөнхрөх дөхсөн төрийн албаны данхайсан орон тоог цомотгох замаар одоогийн яам, агентлагуудийн тоог цөөрүүлэх хэрэгтэй. Яамдын орлогч сайд, тэдгээрийн газар, хэлтсийн 10 ажилтны 3-4 нь ахлах зэрэглэлээр цалинждаг, засаг даргын 4-6 орлогч зэргийг цомхотголд нэн түрүүнд оруулах шаардлагатай. Нийт хүн амын 35 хувь нь ядуу амьдарч байхад өдөр тутмын ачаалал харьцангуй багатай, хийсэн ажлаасаа илүү цалин авч байгаа улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчдын орон тоог хасах нь зүй ёсны шударга үйл хэрэг мөнөөс мөн юм.

Нарийн мэргэжил эзэмшсэн, ажлын дадлага туршлага, ур

чадвартай олон зуун залуус АНУ болон Европын өндөр хөгжилтэй орнуудын банк санхүүгийн байгууллага, олон улсад нэр хүндтэй пүүс, компаниудад эх орныхоо алдарыг мандуулан үр бүтээлтэй ажиллацгааж байна шүү дээ.

Үнэн хэрэгтээ Оюу Толгойн төсөлд уг ордыг барьцаалж гадаадын 10 гаруй банк санхүүгийн байгууллагаас авч зарцуулаад байгаа 11 тэрбум ам.долларыг тооцвол Монгол Улсын гадаад өр 50 гаруй тэрбум ам.доллар болохоор байна.

Нэгэнт үүссэн тааламжтай биш нөхцөл байдалд эдийн засгийн нухацтай дүн шинжилгээ хийж, их хэмжээний гадаад өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах менежментийг нарийвчлан гаргуулж, хатуу мөрдлөг болгож ажиллах нь улс төрийн сонгуулиас өмнө авч хэрэгжүүлэх хойшлуулшгүй амин чухал зорилт болж буйг энэ ялдамд онцлон тэмдэглэж байна.

Одоогоор 32 их наяд ам.доллараар үнэлэгдэхээр байгаа байгалийн баялгийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан билээ. Энэхүү түүхэн ач холбогдолтой заалтыг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэх анхны арга хэмжээ болгон “Ахмадуудын тэтгэврийн зээлийг нэг удаа тэглэх тухай УИХ-аас саяхан шийдвэрлэхдээ Салхитын алт, мөнгөний ордын цэвэр ашгаас санхүүжүүлэхээр хуульчилсан шударга ёсонд үнэхээр нийцэж байна. ■

ДЭЛХИЙ

Вьетнамд шийтгэл чангарсан нь шар айргийн борлуулалтыг бууруулав

Торгууль хэт өндөр байна хэмээн гомдоллож буй шар айраг үйлдвэрлэгч компаниуд бүтээгдэхүүнийхээ үнийг хямдрууллаа

Жон Будро

Согтуугаар жолоо баригсдад оноох шийтгэл чангарсны дүнд дэлхийн шар айргийн хамгийн эрчтэй хөгжиж буй зах зээлийн нэг Вьетнамд борлуулалт муудлаа.

Согтуу жолооч нарыг чанга шийтгэх хуулийн зохицуулалт нэгдүгээр сарын нэгнээс хэрэгжиж эхлэн цагдаа нар 6,200 гаруй торгууль оноосны дараа шар айргийн борлуулалт тус улсад лавтай 25 хувиар буурав. Торгууль хэт өндөр байна хэмээн гомдоллож буй шар айраг үйлдвэрлэгч компаниуд билгийн тооллын шинэ жилийн баяраар эрэлт өсгөх үүднээс бүтээгдэхүүнийхээ үнийг хямдрууллаа.

Вьетнамд өнгөрсөн онд согтуу жолоочтой холбоотой дуулиант осол удаа дараа болсонтой холбогдуулж эрх баригчид эрс арга хэмжээ авсан нь согтууруулах ундааны зохицуулалтыг элэг доог болгож ирсэн ууж наргих дуртай улсын иргэдэд гайхмаар зүйл

болгов. Вьетнамд төрийн албан хаагч ажлын цагаар архидад согтуурахыг хориглодог хуулийг иргэд үндсэндээ хайхардаггүй байжээ. Шар айргийн хэрэглээ 2004 оноос хойш дөрөв дахин нэмэгдсэн Вьетнамын зах зээл Heineken NV-гээс Anheuser-Busch InBev хүртэлх дэлхийд тэргүүлэх исгэгчдийн анхаарлыг татдаг боллоо.

Согтуугаар жолоо барьсан мотоцикл, скутерийн жолоочийг шинэ зохицуулалтаар найман сая донгоор (345 ам.доллар) торгодог болсон нь торгуулийн хэмжээ хоёр дахин өссөн хэрэг. Торгуулийн зэрэгцээ жолоо барих эрхийг таван сараар хасдаг байсныг хоёр жил болгожээ. Согтууруулах ундаа үнэртүүлсэн хөнгөн тэрэг, ачааны машины жолоочийг 40 сая донгоор (1,730 ам.доллар) торгож, жолооны үнэмлэхийг нь хураадаг боллоо.

Шинэ хуулиар согтууруулах ундааны сурталчилгаанд эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг сануулсан анхааруулга хавсаргаж байх шаардлага тавьж байна. Мөн дэлгүүрүүд 18-аас доош насныханд



Вьетнамын зах зээл Heineken NV-гээс Anheuser-Busch InBev хүртэлх дэлхийд тэргүүлэх исгэгчдийн анхаарлыг татдаг боллоо.

ТОРГУУЛИЙН ЗЭРЭГЦЭЭ ЖОЛОО БАРИХ ЭРХИЙГ ТАВАН САРААР ХАСДАГ БАЙСНЫГ ХОЁР ЖИЛ БОЛГОЖЭЭ.

согтууруулах ундаа зарахгүйг мэдэгдсэн самбар, анхааруулга байрлуулах үүрэг хүлээв.

Вьетнамын эрх баригчид шинэ хуулийн хэрэгжилтэд нухацтай хандаж байна. Вьетнамын Нийгмийг Аюулаас Хамгаалах Яам

нэгдүгээр сарын эхний 15 хоногийн байдлаар согтуугаар жолоо барьсан 6,279 хэрэг илрүүлж, 21 тэрбум донгийн торгууль оноосныг Vietnam News мэдээлэв.

Вьетнамд 2019 онд согтуу жолоочийн балгаар тохиолдсон олон ослын нэгэнд амиа алдсан эхийнхээ хажууд уйлж буй жаал хүүгийн гэрэл зураг сошиалд тавигдсан нь нийслэл Ханойд архины хуулийн хэрэгжилтийг чангатгахын төлөө кампанит ажил өрнөхөд хүргэжээ. Вьетнамын Эрүүл Мэндийн Яам, тус улсын Үндэсний Ассамблейн дарга Нгуен

Ти Ким Нган зэрэг эмэгтэй улс төрчдийн шахалт, лоббийн дүнд шинэ хууль батлуулж чадсаныг АНУ-Азийн Бизнесийн Зөвлөлийн төлөөлөгч Ву Ту Тан тайлбарласан юм.

Вьетнамд согтууруулах ундааны хэрэглээ ихэссэн нь иргэдийн эрүүл мэндэд хөнөөлт нөлөө үзүүлж буйг эрүүл мэндийн салбарын албаны эрхэм тайлбарлаж байна. Тус улсад жил бүр архины улмаас 79,000 хүн амиа алдаж байгааг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага тооцоолжээ. ■



Наталиа Дроздиак

Хиймэл оюуны салбарт АНУ, Европын Холбоо зохицуулалтаа уялдуулах нь “тулгамдсан шаардлага” болж хувираад байгааг Alphabert Inc, Google-ийн гүйцэтгэх захирал мэдэгдлээ. “Хиймэл оюунд зохицуулалт хэрэгтэй нь эргэлзээгүй” ч зарим тохиолдолд цоо шинэ хууль гаргах, “бүгдийг шинээр эхлүүлэх албагүй”-г Европын эдийн засгийн судалгааны Bruegel байгууллагаас даваа гарагт Брюссельд зохион байгуулсан арга хэмжээн дээр гүйцэтгэх захирал Сундар Пичай анхааруулсан юм.

Захирлын тайлбар нь эрүүлийг

Хиймэл оюунд зохицуулалт хэрэгтэй

хамгаалах, тээвэр зэрэг “эрсдэлтэй салбар”-т хиймэл оюун ухаан хөгжүүлэгчид баримтлах хууль зүйн шинэ шаардлага багтаасан зохицуулалтыг Европын Холбоо албан ёсоор хуульчлахаас хэдхэн долоо хоногийн өмнө гарч байна. Тус холбооны шинэ зохицуулалт нь хиймэл оюун хөгжүүлэгч компаниудад бүтээж буй системээ ил тод байлгах шаардлага тавьж байгаа юм.

Ноё Пичай Брюссельд байх хугацаандаа Европын Холбооны өрсөлдөөний хэрэг эрхэлсэн комиссар, Google-д монополийн хэргээр найман тэрбум еврогийн (8.9 тэрбум ам.доллар) торгууль оноочихоод байгаа Маргрет Вестагертэй уулзах ёстой. Вестагер нь тус холбооны өрсөлдөөний хэргийн зэрэгцээ хиймэл оюуныг хуульчлах асуудлыг оролцуулаад дижитал бодлого мөн хариуцдаг юм.

Alphabert Inc нь Европ тивд зохицуулалтын дарамттай тулгараад олон жилийн нүүр үзэж байна. Интернет хайгуулын аварга Европын Холбооноос

монополийн хэргээр оноосон олон тэрбум ам.долларын торгуулийн зэрэгцээ зохиогчийн эрх зэрэг Брюсселиас үүдэлтэй бусад олон зохицуулалтын асуудлаар ч маргаантай хэвээр. Google-ийн захирал Европын холбооны хуулийн зохицуулалт “нийтэд хохиролгүй, тэнцвэр бариулсан, пропорционал” байж чадна гэдэгт найдаж байгаагаа илэрхийлсэн юм.

Царай таних технологи, deep fake буюу хуурамчаар үүсгэсэн аудио, видео контент нь хиймэл оюун ухаан сүйрүүлэгч уршиг тарьж болзошгүй хоёр салбар хэмээн захирал үзлээ. Тэр бээр уг хоёр салбарт компаниуд “юмыг зөв хийх ёстой” хэмээн анхааруулав.

Google хуурамч контент илрүүлж таних хэрэглүүр үүсгэхэд судлаачдад хэрэгтэй өгөгдлийн нээлттэй сан үүсгэснийг мэдэгдсэн захирал мөн нийтийн ерөнхий зориулалттай царай таних программын интерфэйс үүсгэхгүй байх нь зүйтэй хэмээн зөвлөж байна. ■

БНХАУ-ын ихэнх мужийн эдийн засгийн өсөлт саарна

Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлагатай уялдаж БНХАУ-ын ихэнх мужийн эдийн засгийн өсөлт 2020 онд саарах төлөвтэй байгаа нь ирэх гуравдугаар сард хуралдах хууль тогтоох байгууллагын хуралдаанаар эрх баригчид зорилтоо шинэчлэн тодорхойлоход хүргэж болзошгүй.

Энэ оны төлөвлөгөөний бүрдэл болох ёстой дотоод ажлын тайлангаас нь үзвэл, БНХАУ-ын 31 том хот, муж, өөртөө засах орноос 22 нь 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүн өсгөх зорилтоо бууруулж өөрчилжээ. Өнгөрсөн оны есдүгээр сарын байдлаар БНХАУ-ын эдийн засгийн хүчин чадлын 42 хувь нь оногдож байсан 12 муж энэ жил өсөлт зургаа юм уу зургаагаас доош

хувьтай байх болно хэмээн үзлээ. Мөн есөн муж 2020 онд эдийн засгаа 6-6.5 хувьтай өсөхөөр тооцоолжээ.

Хятадын хөгжил удаашрах хандлагатай болсон тул Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурал 2020 оны эдийн засгийн өсөлтийн зорилтыг “зургаан орчим” хувьтай тогтооно хэмээн шинжээчид таамаглаж байна. Өмнөх 2019 оны эдийн засгийн өсөлт


6.1 хувьтай гарсныг тус улс ердөө өнгөрсөн долоо хоногт зарласан.


Хэдийгээр өсөлт удааширсан ч дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ таван их наяд юань буюу 729 тэрбум ам.доллараар нэмэгдсэн нь Швейцарын ДНБ-ээс их байгаа юм. ■




PEN BOUTIQUE

2nd floor, Central tower, 2
Sukhbaatar square, khoroo 8,
Sukhbaatar district

 penboutiquemongolia

 penboutique.mn

 7000-9880



Аав, ээж болохын өмнөх BabyMoon аялал

О.Даваасүрэн, ЗГМ сонин

Хуримаа хийсэн шинэхэн хосууд бал сарын аялалд гарч, романтик дурсамж бүтээдэг. Тэгвэл сүүлийн үед бүл нэмэхээр зэхэж буй аав, ээжүүд ч мөн аялалд гарч, удахгүй эхлэх завгүй амьдралын хэв маягтаа сэтгэл зүйгээ бэлтгэдэг шинэ хандлага Европын орнуудад бий болжээ. BabyMoon буюу ирээдүйн эцэг, эхийн аялал нь хосуудын харилцаанд эерэг нөлөөтэй болохыг судлаачид тогтоосон байна. Энэ талаар хосын сэтгэлзүйч, доктор Сибитта Пиллай-Фридман “Хосын харилцаанаас ээж, аавын амьдралд шилжихээр асар их

үүрэг хариуцлага нэмэгддэг. Үүний улмаас хосуудын дунд үл ойлголцол бий болох, хариуцлагаас зугтах, шинэ амьдралдаа дасан зохицохгүй байх зэрэг хүндрэл бий болдог. Төрсөн эмэгтэйн сэтгэл гутрал, дааврын өөрчлөлт ч хүндээр нөлөөлдөг. Тиймээс аав, ээж болохоосоо өмнө хосууд, хоёулхнаа романтик аялалд гарч, дурсамж бүтээснээр бат, бөх харилцаа бий болдог. Учир нь аялалд явснаар олон цагийг хамтдаа өнгөрөөж, сайн ярилцаж, ойлголцдог төдийгүй хэзээ ч мартагдашгүй, дахин давтагдашгүй дурсамж бүтээдэг. Энэ нь хүүхэд төрсний дараах хямралыг даван туулахад тус болдог” хэмээжээ.

Хосын аялалд төрсний дараах хямралыг даван туулахад тус болдог

БАВУМООН АЯЛАЛД ЖИРЭМСНИЙ 12 ДОЛОО ХОНОГТОЙД ЯВАХАД ТОХИРОМЖТОЙ

Алжаалаа тайлж, аав, ээж болоход сэтгэл зүй, бие физиологи бэлтгэх BabyMoon аялалд жирэмсний 12 долоо хоногтойдоо явахад хамгийн тохиромжтойг эмч нар зөвлөдөг байна. Учир нь 12 долоо хоногтойгоос жирэмсний хоёр дахь триместрийн үе эхэлдэг аж. Энэ үед хордлогын шинж тэмдэг бүрэн арилдаг төдийгүй сүүлийн саруудын хүндрэл ээжид мэдрэгдэж эхлээгүй байдаг. Тиймээс жирэмсний хамгийн

жаргалтай мөч хэмээдэг байна. Түүнчлэн ихэнх усан онгоцны аялалд 27-гоос дээш долоо хоногтой жирэмсэн эмэгтэйчүүдийг далайд гарахыг хориглодог. Тиймээс ээжийн бие эрүүл, хүндрэлгүй, ургийн өсөлт хэвийн бол жирэмсний хоёр дахь триместрийнхээ үед аялалд гараарай. Ингэснээр ямар нэг зовуурь, хүндрэлгүй аяллаа аз жаргал, дурсамж дүүрэн өнгөрүүлэх болно.

ХҮН БАГАТАЙ, БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНД АЯЛАХ ТОХИРОМЖТОЙ

Зарим хүн эрсдэл бүхий, адал явдалтай аялалд дуртай байдаг. Тухайлбал, ууланд авирах, нисдэг тэрэгнээс үсрэх, ойд ганцаараа алхах зэргээр өөрийгөө туршиж, мэдрэмжээ сэлбэдэг. Тэгвэл BabyMoon аялал бусад аяллаас онцлогтой. Учир нь эхийн хэвлийд ураг бүрэлдэж буй учир аялал ямар нэгэн эрсдэлгүй байх хэрэгтэй. Мөн удаан хугацаанд үргэлжлэх нойргүй шөнүүдийн өмнөх

бэлтгэл учир бие, сэтгэлээ амрааж болохуйц хүн, хөдөлгөөн багатай газрыг сонгоорой. Энэ нь бие, биеэ ойлгож, ярилцахад ч чухал нөлөөтэй. Мөн гар утас, интернэт ашиглах боломжгүй, байгалийн цогцолбор газар хамгийн тохиромжтой байдаг аж. Учир нь эрүүл мэндэд тустай төдийгүй амьд харилцаа бий болгох боломж бүрдүүлнэ.

2020 онд аялахад тохиромжтой улсууд

Дэлхийн шилдэг аяллын хөтчийн нэг болох Lonely Planet компани 2020 онд аялахад тохиромжтой улс орныг тодруулжээ. Энэхүү жагсаалтыг гаргахдаа аялагчдын дунд хийсэн судалгааг үндэслэн, байгальд ээлтэй аялал, аялагчдад үлдэх сэтгэгдэл, туршлага зэргийг тооцоолсон байна.

Жагсаалтын нэгдүгээрт, Гималайн нурууны зүүн хошуунд орших Бутаны Вант Улс тодорчээ. Тус улсын талаар Lonely Planet компанийн сэтгүүлч Жо Биндлос “Гималайн нурууны зүүн хошуунд орших Аянгат луугийн орон хэмээн нэрлэгддэг Бутан улс нь өндөр үнэтэй атлаа байгаль орчинд хор хөнөөл багатай аяллын бодлого хэрэгжүүлдэг. Бутан

улсыг зорьсон жуулчид уулсын оройд орших хийдэд зочлохын тулд их өртөг зарцуулдаг. Түүнчлэн Бутан нь нүүрс-төрөгчийн хэрэглээг хориглосон цор ганц улс бөгөөд 2020 онд байгальд ээлтэй орон болохоор төлөвлөсөн” хэмээжээ. Ийнхүү аялахад хамгийн таатай нөхцөл, уур амьсгалтай улс орнуудын жагсаалтыг толилуулж байна.

- #1 Бутан
- #2 Англи
- #3 Умард Македон
- #4 Аруба
- #5 Эсватинийн Вант Улс
- #6 Коста Рика
- #7 Нидерланд
- #8 Либерти
- #9 Марокко
- #10 Уругвай



ТОВЧХОН

■ БОКС

Туркийн Истанбулд Ахмет Комертын нэрэмжит олон улсын XXXIII тэмцээнд хүчээ сорьсон Монголын боксчид гурван алт, хоёр мөнгө, хоёр хүрэл медаль хүртжээ. Тус тэмцээнд Х.Энхмандах, Х.Энх-Амар, Б.Чинзориг нар төрийн дууллаа эгшиглүүлсэн байна. Монголын ширэн бээлийтнүүд багаараа дэд байрт шалгарчээ.

■ САГСАН БӨМБӨГ

Сагсан бөмбөгийн 3x3 төрлийн олимпын эрхийн тэмцээнд оролцох үндэсний шигшээ багийн тоглогчид буурал тивийг зорьжээ. Тэд ирэх сарын 1-нд Сербид болох дэлхийн шилдэг зургаан орны тэмцээн, ирэх сарын 8-нд зохион байгуулах өндөр зэрэглэлийн найман орны тэмцээн болон хамтарсан бэлтгэлд оролцохоор өчигдөр эх орноо мордлоо. Манай тамирчдын оролцох олимпын эрхийн тэмцээн гуравдугаар сарын 18-нд Энэтхэгийн Делид, дөрөвдүгээр сард Унгарын Будапешт хотод тус тус болно.

■ БИАТЛОН

Швейцарын Ленцерхайде хотод өсвөр болон залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 23-нд эхэлнэ. Уг тэмцээнд Монголын биатлоны баг тамирчид оролцохоор болж, өсөн тамирчин дасгалжуулагч С.Ганболд, Беларусийн гавьяат дасгалжуулагч Александр Попов нарын удирдлага дор өрсөлдөнө. 44 орны 500 гаруй тамирчин оролцох ДАШТ-д өсвөрийн охидын төрөлд А.Төмөр, хөвгүүдийн төрөлд А.Билгүүн, Ц.Адьяажаргал нар өрсөлдөх бол залуучуудын ангиллын эмэгтэйчүүдэд Ч.Бямбасүрэн, М.Должинсүрэн, эрэгтэйчүүдэд Э.Энхсайхан, Б.Далхсүрэн, Б.Тайванбаатар, Б.Гомбоням нар хурд, цэцээ сорино.

■ ЖУДО



Жүдогийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн энэ амралтын өдрүүдэд Эрдэнэт хотод болно. Уг тэмцээнд одоогоор 350 гаруй бөх өрсөлдөхөөр мэдүүлэг өгчээ. Тэмцээнийг MNB sport суваг орон даяар шууд дамжуулахаар бэлтгэлээ базаасан байна. Сонирхуулахад, улсын аварга шалгаруулах тэмцээний 81 кг-ын жинд Монголын иргэншил авсан иран бөх Саейд Моллай зодоглох бололтой.

Кемба Уокер анх удаа Леброн Жеймсийг ялав

Мөнхийн өрсөлдөөн “Бостон Селтикс”-ийн ялалтаар өндөрлөлөө

✍ Б.Мөнхзул, ЗГМ сонин

Дэлхий дахинд хамгийн их үзэгчтэй Америкийн үндэсний сагсан бөмбөгийн лигт өчигдөр 14 тоглолт боллоо.



Сагсан бөмбөг сонирхогчдын анхаарлыг хамгийн их татсан тоглолт “Бостон Селтикс”, “Лос-Анжелес Лейкерс”-ийн хооронд боллоо. NBA-ийн түүхэн дэх хамгийн урт удаан, баялаг түүхтэй, мөнхийн өрсөлдөгч багууд “Бостон Селтикс”-ийн “ТД Гарден”-д учраа таарсан нь энэ. Уг тоглолт эхнээсээ л өрсөлдөөнтэй болж, эцэст нь Леброн Жеймс тэргүүтэй “Лейкерс”-ийн залуус ялалт байгуулна хэмээн сонирхогчид хооронд бооцоо тавьсан. Гэвч эхнээсээ л дүр зураг өөр байсан бөгөөд талбайн эзэд дөрвөн үеийн турш илүүрхсээр өрсөлдөгчөө 139:107-гоор буулган авлаа. “Селтикс”-чүүд нэг үед хамгийн багадаа 33 оноо

авч байсан “Лейкерс” зөвхөн нэгдүгээр үед л 30 оноо цуглуулжээ. Энэхүү тоглолтод “Бостон Селтикс”-ийн довтлогч Жэйсон Тэйтум 27 оноогоор багаа тэргүүлсэн түүнд Жайлон Броун 20 оноогоор тусалжээ. Харин хожигдсон “Лейкерс”-ээс Жавал Макги онооны лидер байж 18 оноо цуглуулсан гэхээр бусад нь хэр тоглосон талаар дурдаад ч хэрэггүй биз. Багийн лидерүүд болон Леброн Жеймс 15, Энтони Дэвис

“Селтикс”-чүүд нэг үед хамгийн багадаа 33 оноо авч байсан “Лейкерс” зөвхөн нэгдүгээр үед л 30 оноо цуглуулжээ.

дөнгөж өсөн оноо авсан “Лейкерс”-ийн залуусыг 32 онооны зөрүүтэй хожигдоход гол нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. Тус тоглолтын үеэр нэгэн онцгой зүйл болсон нь Кемба Уокер өөрийн замналдаа анх удаа Леброн Жеймсийг хожиж, хоорондын харьцаагаа 1:28 болгов. Ингээд хоёр багийн тоглолттой холбоотой зарим мэдээллийг хүргэе. ■



Кемба Уокер Леброн Жеймсийг анх удаа хожсон тоглолтдоо 20 оноо авсан юм.

- Кемба Уокер Леброн Жеймсийн эсрэг 29 удаа тоглож анх удаа хожжээ.
- Дуайт Ховард NBA-ийн түүхэнд нэг тоглолтод хамгийн олон чөлөөт шидэлтийн оролдлого хийсэн тоглогч юм. (39 удаа)
- Бостон Селтикс баг 32 онооны зөрүүтэй Лэйкерсийг буулгаж авлаа
- “Бостон Селтикс”-ийн залуус “Лейкерс”-ийг хамгийн сүүлд 1963 онд 32 оноотой зөрүүтэй хожиж байв. Түүнээс хойш 57 жилийн дараа дахин 32 оноогоор хожсон нь энэ.

ТОКИО-2020

Олимпын бэлгэ тэмдгийг Токиод байрлуулжээ

Олимпын наадмын бэлгэ тэмдэг болох цэнхэр, шар, хар, ногоон, улаан өнгийн таван цагаригийг Японы нийслэл Токио хотын Odaiba далайн паркт байрлуулжээ. Ёкохома хотод бүтээсэн уг хөшөө 32.6 метр өргөн, 15.3 метр өндөр аж. “Токио хотын оршин суугчид болон дэлхийн өнцөг булан бүрээс ирэх жуулчид, аялагчдад зориулан олимпын уур

амьсгалыг бүрдүүлэх зорилгоор хийж буй хотын засаг захиргааны гол санаачилгуудын нэг нь энэхүү хөшөө юм” гэж зохион байгуулагчид мэдээлсэн байна. Дашрамд дурдахад, наймдугаар сарын 25-наас есдүгээр сарын 6-нд паралимп эхэлнэ. Энэ үеэр уг хөшөөг паралимпын наадмын бэлгэ тэмдгээр солих ажээ. ■

Олимпын тасалбар хавраас худалдаанд гарна

Олимп, паралимпын наадмын тасалбарын 84 загварыг тус олон нийтэд албан ёсоор танилцуулав. Токиогийн олимпыг зохион байгуулах хорооны мэдээлснээр, тасалбарын загваруудад Японы уламжлалт дөрвөн өнгө болох гүн улаан, хөхөлбөр нил, цайвар туяатай хөх ягаан, гүн ногоон өнгийг ашиглажээ. Түүнчлэн эдгээр өнгө нь

тэмцээн болох газруудыг тус тус илэрхийлэх юм байна. Мөн паралимпын наадмын тасалбарын цахим сугалааны хоёр дахь үе шат эхэлжээ. “Токио-2020” наадмыг зохион байгуулах хороо олимп, паралимпын наадмын тасалбаруудыг ирэх хавраас цахим хуудсаараа болон Токио хотын дэлгүүрүүдээр худалдаалахаар төлөвлөсөн байна. ■



БАЛДОРЖ шагнал

Сэтгүүл зүйн шилдэг бүтээлд олгодог БАЛДОРЖ шагналын 2020 оны I улирлын дүн гарлаа. Зөвлөх багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, гурван гишүүн хасагдан, хоёр гишүүн нэмэгдсэнээр нийт есөн гишүүнтэй болов. Шүүгчдийн бүрэлдэхүүн зөвлөх багийн санал болгосон гурван бүтээлд давхардсан санал өгснөөр I улирлын шалгаруулалтаас нийт 13 бүтээл БАЛДОРЖ шагналд нэр дэвших эрхээ авлаа.

ЗӨВЛӨХ БАГИЙНХНЫ ИЛГЭЭСЭН САНАЛУУД



Г.ОТГОНБАЯР
www.itoim.mn сайт

С.Батбаатар
Хэмэл мэдээллийн салбар 30 гаруй жил ажилласан турвилагатай. УИХ-ын Хэмэл мэдээлэл, олон нийтийн харилцах хэлтсийн дарга

- “Хов зөөсөн хэл бус, хор сонссон чих бурууддаг” нийтлэл
- “Талын урсгалд ганц Хүрэлсүх таанц эргэхгүй” нийтлэл



Б.Гомболд
Хэмэл мэдээллийн салбар 40 гаруй жил ажиллаж буй турвилагатай. Соёлын агаарын зурвас, “Монголын үсэм” сонинны ерөнхий эрхлэгч

- “Цезарьгүй яриа” цуврал ярилцлага



Б.Ганымэг
Соёлын агаарын зурвас, агаар БАЛДОРЖ шагналтан, МОНЦАМЭ агаарын зурвас

Б.АЛТАНХҮЯГ
МОНЦАМЭ агентлагийн тоймч

- “Эгшин мэт дуурсагч тэр” нийтлэл



Б.НЯМЗҮЛ Сэтгүүлч (“Гэрэг”, “Нью Йорк таймс” сэтгүүлийн хамтарсан дугаар)

- Иргэнээс хот хүртэх зам



Г.Гануун
Монгол коммент, дорнод сайтын үзсэн байгуулагчийн нэр, “Новадх коммент”-ын ерөнхий захирал

МҮОНР-ийн Эрэн сурвалжлах редакц

- “Нэг улс, хоёр бодлого” нэвтрүүлэг
- “Хязгааргүйн хязгаар” цуврал нэвтрүүлэг



Л.Нямжав
МҮОНР-ийн ерөнхий захирал

МҮОНР-ийн Эрэн сурвалжлах редакц

- “Нэг улс, хоёр бодлого” нэвтрүүлэг
- “Хязгааргүйн хязгаар” цуврал нэвтрүүлэг
- “Хуулиар халхалсан даатгал” нэвтрүүлэг



Ж.Сандагдорж
Хэмэл мэдээллийн салбар 30 гаруй жил ажиллаж буй турвилагатай. “Өдрийн сонин”-ын ерөнхий эрхлэгчийн орлогч

Б.АМАРТҮВШИН
“Өдрийн сонин”

- Дархлагдсан “дээрэмчин” хүрэн баазгийн “дошин” дээрээс сурвалжиллаа



Х.БАТСАЙХАН
“Үндэстний ТОЙМ” сэтгүүл

- “Популизмтай попури” нийтлэл



Э.Хүрэлбаатар
“Үндэстний шуудан” сонинны ерөнхий эрхлэгч

“Үндэстний шуудан” сонинны Эрэн сурвалжлах алба

- “Шонхор аних дон буюу арбуудын аархал” цуврал сурвалжлага
- “Усны төсөв ураг төрийн хэсэг” цуврал нийтлэл
- “ХЭДС-г цөлмөсөн УИХ-ын гишүүд, дарга нартай танилц” цуврал нийтлэл

2020 ОНЫ БАЛДОРЖ ШАГНАЛТНЫГ ТОДРУУЛАХ ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН




- Намсрайн ШҮР - “Балдорж сан”-гийн үүсгэн байгуулагч
- Эрдэнэцогтын СОНИНТОГОС - СУИС-ийн захирал, доктор, профессор
- Бадамгаравын БАЯРМАГНАЙ - “Балдорж сан”-гийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
- Цэрэнпилэйн АРИУНАА - “Guru media”-гийн гүйцэтгэх захирал
- Журын БАЯНСАН - Гавьяат багш, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор
- Пүрэвхүүгийн БАТХҮЯГ - Зохиолч, судлаач, доктор
- Гомбын ЗОЛЖАРГАЛ - Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч, МҮОНР-ийн редактор
- Баарангийн ПҮРЭВДАШ - Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч, доктор
- Сампилдондвийн ЧУЛУУН - Олон улсын монгол судлалын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, академич
- Жамьян-Очирын ТЭГШЖАРГАЛ - БАЛДОРЖ шагналт, сэтгүүлч

БАЛДОРЖ ШАГНАЛЫН XII УДААГИЙН ШАЛГАРУУЛАЛТЫН НЭГДҮГЭЭР УЛИРАЛ (09.20-12.31) ШҮҮГЧДИЙН НЭР ДЭВНҮҮЛСЭН БҮТЭЭЛ

- МҮОНР-ийн Эрэн сурвалжлах редакц
 - “Нэг улс, хоёр бодлого” баримтат нэвтрүүлэг
 - “Хязгааргүйн хязгаар” цуврал нэвтрүүлэг
 - “Хуулиар халхалсан даатгал” баримтат нэвтрүүлэг
- Г.ОТГОНБАЯР www.itoim.mn сайт
 - “Хов зөөсөн хэл бус, хор сонссон чих бурууддаг” нийтлэл
 - “Талын урсгалд ганц Хүрэлсүх таанц эргэхгүй” нийтлэл
- Х.БАТСАЙХАН “Үндэстний ТОЙМ” сэтгүүл
 - “Популизмтай попури” нийтлэл

ХЭР ИХИЙГ УНШИХ НЬ БУС ЮУГ СОНГОЖ УНШИХ НЬ ЧУХАЛ

НӨХӨРСӨГ ФОРМАТ | АЖИЛ ХЭРЭГЧ НИЙТЛЭЛИЙН БОДЛОГО | ОЛОН ТАЛЫН МЭДЭЭЛЭЛ



Улиралд 30,000₮ | Хагас жилд 60,000₮ | Жилд 120,000₮

QR КОД | УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА ТА ЯГ ОДОО ЗАХИАЛ

Та мобайл банкны аппликэйшнаараа QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт **и-мэйл хаяг, утасны дугаараа** бүртгүүлж, “Засгийн газрын мэдээ” сонинийг захиалаарай.



ХОНКОНГ ГЭЭР БҮЛ ОНЦГОЙ ҮНЭ



2-11 насны хүүхэд
ҮНЭГҮЙ

Брэндээ олон улсын зах зээлд гаргахаар ажиллаж байна

Н.А.ЛИМА:



✍ О.Даваасүрэн, ЗГМ сонин

БНХАУ-ын Ханжоу хотод үйл ажиллагаа явуулж буй гадаад худалдааны Hangzhou stardust компанийн үүсгэн байгуулагч Н.Алимааг энэ удаагийн "Гоо сайхан" буландаа онцолж байна. Тэрбээр Lima's bikini collection дотуур хувцасны брэндтэй бөгөөд одоогоор бүтээгдэхүүнээ БНХАУ-ын хэрэглэгчдэд хүргэж буй. Бизнесээ өргөжүүлэн, олон улсын зах зээлд гарах зорилготой дэгжин бүсгүй загварын ертөнцөд ч цахилж яваа нэгэн. Тэрбээр Хонконгийн Kelly cosmetics брэндийн Healthy beauty төслийн нүүр царайгаар ажилладаг бөгөөд бикини модель юм.

- **Биеийн жин:** 53кг
- **Биеийн өндөр:** 165см
- **Биеийн харьцаа:** 92:60:92
- **Биеийн хамгийн дуртай хэсэг:** Бэлхүүс, тааз
- **Орд:** Охин
- **Төрсөн он, сар, өдөр:** Хэлмээргүй байна
- **Үсний өнгө:** Бор
- **Нүдний өнгө:** Бор
- **Төгссөн сургууль:** Урлах эрдэм их сургууль
- **Ажил:** Hangzhou stardust компани болон Lima's bikini collection брэндийн захирал, модель
- **Мэргэжил:** Бизнесийн удирдлага, загвар зохион бүтээгч
- **Идэх дуртай хоол:** Итали, Япон хоол
- **Дуртай өнгө:** Цагаан
- **Хобби:** Фитнесээр хичээллэх, аялах, зураг дарах
- **Зорилго:** Брэндээ олон улсын зах зээлд гаргах
- **Баримталдаг зарчим:** Хүлээцтэй байх, аливаад эерэг хандах
- **Нууц авьяас:** Олон төрлийн коктэйл хийж чаддаг
- **Үзэх дуртай кино:** Matrix 1,2,3
- **Багын хоч:** Байхгүй
- **Хэлэх дуртай үг:** Хүс, хий хүр
- **Instagram:** badmaa11

✎ Б.Мөнхзул, ЗГМ сонин

Сүүлийн үед бөх сонирхогчид төдийгүй хэвлэлийнхний гол бай нь Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадмын түрүү бөх, улсын аварга Э.Оюунболд болоод байна. Учир нь, түүнээс допинг илэрсэн нь монгол наадмын түүхэнд тохиолдоогүй хар үйл явдал юм. Гэхдээ улсын аварга Э.Оюунболд үүнийгээ хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд допингийн шинжилгээ авдаг мэргэжилтнүүдийг АТГ-т шалгуулахаар хүсэлт гаргасан. Түүгээр зогсохгүй өөрийгөө хэлмэгдсэн хэмээн мэдэгдээд буй. Тэр утгаараа сар шинийн барилдаан зодоглохоо дуулгасан юм. Цагаан сарын барилдааны бэлтгэлдээ ч орсон тухай мэдээлэл бий. Харин бөхчүүдийн олонх үүнийг эрс эсэргүүцэж, хэрвээ Э.Оюунболдыг барилдвал зодоглохгүй гэдгээ эхнээсээ мэдэгдэж байна. Бид допингийн асуудал бол бөхийн ертөнцөд өрнөж буй мэдээллүүдийн хүрээнд Монголын үндэсний бөхийн холбооны дэд тэргүүн, улсын заан Ц.Магалжавтай ярилцлаа.

-Хэвлэл болон бөх сонирхогчдын хэл амны бай болоод байгаа Э.Оюунболдын асуудлаар ярилцлагаа эхлүүлэе. Тэр саяхан цагаан сарын барилдаанд зодоглоно гэжээ. Үнэхээр барилдаж болох юмуу?

-Монголын Үндэсний бөхийн холбоо допингтой хатуу тэмцэнэ. Бөхийн барилдаан зохион байгуулах үндсэн эрхтэй байгууллагын хувьд хатуу тэмцэх байр суурь хэвээр. Өнгөрсөн жил таван бөх допинг хэрэглэсэн асуудалд бид мөн л хатуу байр суурьтай байгаа. Одоо ч хэвээр байна. Цол хураах хураахгүй гэдэг бол Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг асуудал. Хоёр жилээр эрхийг нь хассан тул цагаан сараар барилдахгүй ээ. Ө.Энхтүвшин сайдаар ахлуулсан Баяр наадмын комиссоос барилдах эрхийг нь хоёр жилээр хассан. Хассан тогтоолоо Үндэсний бөхийн холбоонд 12 дугаар сард



